

Сангийн сайдын 2023 оны 12 дугаар  
сарын 25-ны өдрийн А/261 дүгээр  
тушаалын нэгдүгээр хавсралт

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

ХАРЬЦУУЛАЛТЫН АРГААР  
БАРАА ХУДАЛДАН АВАХ  
ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН  
ЖИШИГ БАРИМТ БИЧИГ

2024 он

## ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

# ХАРЬЦУУЛАЛТЫН АРГААР БАРАА ХУДАЛДАН АВАХ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН БАРИМТ БИЧИГ

Тендер  
шалгаруулалтын  
нэр:

Тендер  
шалгаруулалтын  
дугаар:

Аймгийн Нэгдсэн эмнэлэгт Бичиг хэрэг,  
маягт нийлүүлэх гүйцэтгэгч сонгох

ХӨАНЭ/20240202011

БАТЛАВ:

ХӨВСГӨЛ АЙМГИЙН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН ЗАХИРАЛ  
..... Г.ОЮУНЖАРГАЛ

Мөрөн сум  
2024 он

## САНАМЖ

Тендер шалгаруулалтын баримт бичиг болон шалгарсан оролцогчийн ирүүлсэн тендер нь захиалагч, шалгарсан оролцогчийн хооронд байгуулах бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээний гол нөхцөл болох тул тендер шалгаруулалт зохион байгуулах, түүнд оролцохын өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, түүнийг даган батлагдсан журам, заавар, дүрэм, гэрээний нөхцөл, тендер шалгаруулалтын жишиг баримт бичигтэй сайтар танилцахыг зөвлөж байна.

Захиалагч нь тендер шалгаруулалт зохион байгуулахад худалдан авах ажиллагааны үндсэн зарчмууд болох өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, хариуцлагатай, үр ашигтай, хэмнэлттэй байх зарчмыг баримтална.

Энэхүү харьцуулалтын аргын тендер шалгаруулалтын баримт бичиг нь тендер шалгаруулалтын зааварчилгаа, өгөгдлийн хүснэгт, техникийн тодорхойлолтын шаардлага, тендерийн жишиг маягт, гэрээний нөхцөл гэсэн бүлэгтэй.

Тендер шалгаруулалтын зааварчилгаа (цаашид “ТШЗ” гэх) бүлгийн зүйл, заалтыг нэмж, эсхүл өөрчилж үл болох бөгөөд захиалагч, оролцогч-сонирхогч этгээд нь тэдгээрийг баримтална. Захиалагч тендерийн баримт бичгийг боловсруулахаа ТШЗ-нд үндэслэн, худалдан авах барааны онцлогийг харгалзан өгөгдлийн хүснэгт (ӨХ)-ийг боловсруулах ба шаардлага, шалгуур үзүүлэлт, гэрээний нөхцөл, тендерийн жишиг маягт, техникийн тодорхойлолт болон тэдгээрт иш татсан хууль, журам, зааврыг судалж, түүнд өөрчлөлт оруулсан бол өөрчлөлтэд нийцүүлэн бэлтгэнэ.

Техникийн тодорхойлолт бүлэгт захиалагчийн худалдан авах бараа, ажил, үйлчилгээний шинж чанар, түүний зориулалт болон зориулалтын дагуу ашиглахтай холбоотой хэрэгцээ, шаардлага, зураг төсөл, холбогдох стандарт, норм, дүрэм, зааврыг тусгасан байна.

Оролцогч нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлага, шалгуур үзүүлэлтэд үндэслэн жишиг маягтуудын хаалт дотор налуугаар бичсэн тохирх мэдээллийг зааварт нийцүүлэн бүрэн, үнэн зөв бөглөж ирүүлнэ. Гэрээний нөхцөл бүлэг нь захиалагч, шалгарсан оролцогчийн хооронд байгуулагдах гэрээний зүйл, заалтууд тул талууд үүнийг судалсан байвал зохино.

Харьцуулалтын аргын тендер шалгаруулалтын анхаарах асуудлууд:

- ❖ Харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээ /Бараа цахим каталогт бүртгэгдсэн байна./
- ❖ Тендер шалгаруулалтын зарлал нийтэлж, бүртгэлтэй аж ахуй эрхлэгчид урилга хүргүүлж, үнийн санал дуудна. Тендер шалгаруулалтын баримт бичгийг цахим систем [/www.tender.gov.mn/-д нийтэлнэ.](http://www.tender.gov.mn/)
- ❖ Үнийн саналыг дуудах хугацаа нь урилга хүргүүлсэн, зарлал нийтэлсэн өдрөөс хойш ажлын 5-аас доошгүй өдрийн дараа байхаар тогтоосон байна.
- ❖ Үнийн санал дуудах ажиллагаанд бүртгүүлсэн сонирхогч этгээдэд цахим системээс ялгах дугаар олгоно.
- ❖ Заасан хугацаанд сонирхогч этгээд тендерийг цахим системд ирүүлнэ.
- ❖ Үнийн санал дуудах ажиллагааг 2 хүртэл цагийн хугацаагаар зохион байгуулна. Уг хугацааны дотор саналыг бууруулан хэдэн ч удаа ирүүлж болно.
- ❖ Үнийн санал дуудах ажиллагаа хаагдахад өсөх дарааллаар **эхэнд эрэмбэлэгдсэн** үнийн санал бүхий оролцогчийг тодорхойлно.
- ❖ Эхэнд эрэмбэлэгдсэн үнийн санал бүхий оролцогчийн **тендерийг хянан үзэж, шаардлага хангасан бол гэрээ байгуулах эрх олгоно.**

Эхэнд эрэмбэлэгдсэн үнийн санал бүхий оролцогчийн тендер шаардлагад нийцээгүй бол удаах **эрэмбэлэгдсэн тендерийг хянан үзнэ.**

## **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН БАРИМТ БИЧГИЙН АГУУЛГА**

I БҮЛЭГ. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА .....	5
II БҮЛЭГ. ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ .....	12
III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА .....	15
IV БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ЖИШИГ МАЯГТ .....	27
V БҮЛЭГ. ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ .....	30

## I БҮЛЭГ. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА

<b>A. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ</b>	
<b>1. Тендерийн цар хүрээ</b>	<p>1.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “Хууль” гэх)-ийн дагуу өгөгдлийн хүснэгт (цаашид “ӨХ” гэх)-д заасан захиалагч III бүлэгт тодорхойлсон бараа, түүний дагалдах үйлчилгээ (цаашид “бараа” гэх) худалдан авахаар тендер шалгаруулалтын баримт бичгийг гаргаж байна. Зарлалын дугаар, тендер шалгаруулалтын нэр, дугаар, багцын мэдээлэл өгөгдлийн хүснэгтэд бичигдэнэ.</p>
<b>2. Санхүүжилтийн эх үүсвэр</b>	<p>2.1. Төсөл, арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэр, төсөвт өртгийг өгөгдлийн хүснэгтэд тусгана.</p>
<b>3. Худалдан авах ажиллагааны тогтоомж хууль</b>	<p>3.1. Энэ худалдан авах ажиллагаанд хуулийн 2.1-д заасан төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.</p> <p>3.2. Худалдан авах ажиллагаанд захиалагч, сонирхогч этгээд, оролцогч болон хуулийн 52.1-д заасан ажилтан, албан тушаалтан Авлигын эсрэг хууль, Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулиар хориглосон үйлдэл, эс үйлдлийн талаар холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад хууль тогтоомжийн дагуу мэдэгдэнэ.</p>
	<p>3.3. Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20, 20<sup>1</sup>, 21 дүгээр зүйлд заасан хориглолт, хязгаарлалтад хамаарах этгээд тендер шалгаруулалтад оролцох эрхгүй.</p>
<b>4. Оролцогч, сонирхогч этгээдэд тавигдах ерөнхий шаардлага</b>	<p>4.1. Оролцогч хуулийн 7.1.1-7.1.9-д заасан нөхцөлийг хангасан байна.</p> <p>4.2. Түншлэлээр оролцох тохиолдолд түншлэлийн гишүүн бүр ерөнхий шаардлага хангасан байна.</p> <p>4.3.. Аж ахуй эрхлэгч нь хуулийн 22.10-т зааснаар үйлчилгээний хураамж төлснөөр тус тендер шалгаруулалтын сонирхогч этгээд болно.</p> <p>4.4. Сонирхогч этгээдийн төлсөн үйлчилгээний хураамжийг аливаа үндэслэлээр буцаан олгохгүй.</p> <p>4.5. Монгол Улсын олон улсын гэрээнд үл нийцэх, худалдааны хоригт хамаарах этгээд тендер ирүүлэх эрхгүй.</p>
<b>5. Туслан гүйцэтгэгч</b>	<p>5.1. Хуулийн 6.4-т зааснаар тендерийн үнийн 20 хүртэл хувьтай тэнцэх гүйцэтгэлийг нэг, эсхүл түүнээс дээш тооны этгээдээр туслан гүйцэтгүүлэх тохиолдолд туслан гүйцэтгэх үүргийг гэрээнд заасан байна.</p> <p>5.2. Туслан гүйцэтгүүлэх хувь хэмжээ тендерийн үнийн 20 хувиас хэтэрсэн, эсхүл туслан гүйцэтгүүлэх тоо хэмжээг заагаагүй бол туслан гүйцэтгэгчид холбогдох баримт бичгийг тендер хянан үзэхэд харгалзан үзэхгүй.</p> <p>5.3. Туслан гүйцэтгэгчийн хувиар оролцохыг зөвшөөрсөн болохыг туслан гүйцэтгэгч цахим системээр баталгаажуулсан байна.</p>
<b>6. Бараанд тавигдах</b>	<p>6.1. Дотоодын үйлдвэрлэлээр хангах боломжтой чанар,</p>

<b>ерөнхий шаардлага</b>	стандартын шаардлага хангасан бараа худалдан авахаас, эсхүл хууль тогтоомжоор барааны гарал үүслийг заавал нотлохоос бусад тохиолдолд оролцогч аль ч улсын гарал үүсэлтэй бараа санал болгож болно. 6.2.Харьцуулалтын аргаар худалдан авах бараа Сангийн сайдын баталсан “Бүртгэл хөтлөх, мэдээллийг баталгаажуулах журам”-ын дагуу хуулийн 4.1.25-д заасан цахим катологид бүртгэгдсэн байна.
<b>7.Худалдан авах ажиллагааны цахим систем</b>	7.1.Харьцуулалтын аргаар ажил гүйцэтгүүлэх тендер шалгаруулалтыг Сангийн сайдын баталсан “Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам”-ын дагуу худалдан авах ажиллагааны цахим систем ( <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> ) /цаашид “цахим систем” гэх/-ээр зохион байгуулна.
<b>Б.АГУУЛГА</b>	
<b>8.Тендер шалгаруулалтын баримт бичгийн бүрдэл</b>	<p>8.1.Тендер шалгаруулалтын баримт бичиг дараах бүлэг болон түүний нэмэлт, өөрчлөлтөөс бүрдэнэ.</p> <p>I Бүлэг. Тендер шалгаруулалтын зааварчилгаа;</p> <p>II Бүлэг. Өгөгдлийн хүснэгт;</p> <p>III Бүлэг. Техникийн тодорхойлолт, тавигдах шаардлага, бараа нийлүүлэлтийн хуваарь;</p> <p>IV Бүлэг. Тендерийн жишиг маягт;</p> <p>V Бүлэг. Гэрээний нөхцөл.</p> <p>8.2.Тендер шалгаруулалтын зарлал, цахим системээр хүргүүлсэн урилга нь тендер шалгаруулалтын баримт бичгийн бүрдэл болохгүй.</p> <p>8.3.Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлага, шалгуур үзүүлэлт, гэрээний нөхцөл, тендерийн жишиг маягт, техникийн тодорхойлолт болон тэдгээрт иш татсан хууль, журам, зааврыг судалж, түүнд нийцүүлэн тендер бэлтгэнэ.</p>
<b>9.Тендер шалгаруулалтын баримт бичгийн талаар тодруулга авах</b>	<p>9.1.Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан асуудлаар тодруулга авах бол энэ тухай хүсэлтийг тендерийн нээлтээс ажлын таваас доошгүй өдрийн өмнө бичгээр захиалагчид гаргаж болно.</p> <p>9.2.Тодруулга авах хүсэлтийг өгөгдлийн хүснэгтэд заасан хаягаар хүлээн авна.</p> <p>9.3.Тодруулга авах хүсэлтийд үйлчилгээний хураамж төлсөн баримтыг хавсаргана.</p> <p>9.4.Захиалагч тодруулга авах хүсэлтийн хариуг албан бичгээр үйлдэж, цахим системд нийтэлснээр хүргүүлсэн тооцно.</p> <p>9.5.Захиалагч тодруулгын үр дүнд тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл ТШЗ-ы 10-д заасныг мөрдөнө.</p>
<b>10.Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах</b>	<p>10.1.Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө захиалагч тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулж болно.</p> <p>10.2.Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулсан бол түүнийг цахим системд нийтэлснээр хүчинтэйд тооцогдоно.</p> <p>10.3.Хэрэв тендер нээхээс ажлын таван өдрийн дотор тендер шалгаруулалтын баримт бичигт оруулсан нэмэлт,</p>

	өөрчлөлтийг оруулсан бол тендер хүлээн авах эцсийн хугацааг ажлын таваас доошгүй өдөр байхаар тооцож, шаардлагатай хугацаагаар сунгана.
<b>11.Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт</b>	<p>11.1.Захиалагч сонирхогч этгээдийн тендер бэлтгэхтэй холбоотой асуултад хариулт өгөх уулзалт зохион байгуулах, эсхүл ажлын талбайтай танилцуулах бол өгөгдлийн хүснэгтэд заана.</p> <p>11.2.Уулзалтад сонирхогч этгээд, түүний төлөөлөл оролцно.</p> <p>11.3.Уулзалтад оролцоогүй аж ахуй эрхлэгч тендер шалгаруулалт шалгаруулалтад оролцож болно.</p>
<b>В.ТЕНДЕР БЭЛТГЭХ</b>	
<b>12.Тендер шалгаруулалтын хэл</b>	<p>12.1.Тендер шалгаруулалтын зарлал, баримт бичиг, урилгыг гадаад хэлээр давхар нийтэлсэн эсэхээс үл хамааран тендер шалгаруулалтын баримт бичиг, тендер шалгаруулалттай холбогдох албан бичиг, захидал, бусад баримт бичиг, оролцогчийн ирүүлэх тендер монгол хэлээр байх ба өөр хэлээр үйлдсэн тендер, түүний доторх баримт бичиг, мэдээллийг орчуулсан орчуулгыг тендерт оролцогч бэлтгэн ирүүлнэ.</p> <p>12.2.Зөвхөн гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусlamжийн хөрөнгөөр санхүүжүүлэх бараа худалдан авах тендер шалгаруулалтын хувьд Монгол Улсын олон улсын гэрээг үндэслэн хэлийг өгөгдлийн хүснэгтэд өөрөөр зааж болно.</p> <p>12.3.Хэрэв ТШЗ-ны 12.2-т заасан тохиолдолд тендер шалгаруулалтын баримт бичгийн монгол хэл болон гадаад хэлээр бэлтгэсэн хувилбар хоорондоо зөрвөл монгол хэлээр бэлтгэсэн хувилбарыг баримтална.</p> <p>12.4.Тендер хянан үзэх, үнэлэхэд захиалагч гадаад хэлээр үйлдсэн баримт бичгийн орчуулгыг үндэслэх ба оролцогч өөрөө, эсхүл бусад этгээд орчуулсан эсэхээс үл хамааран үнэн зөв, зөрүүгүй болохыг захиалагчийн өмнө хариуцна.</p>
<b>13.Тендерийн бүрдэл</b>	<p>13.1.Оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер дараах баримт бичиг, мэдээллээс бүрдэнэ:</p> <p>13.1.1.ТШЗ-ны 14-т заасны дагуу бэлтгэсэн маягтууд;</p> <p>13.1.2.Тендерийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдээс өөр этгээд баталгаажуулсан бол холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн олгосон итгэмжлэл /гадаадын этгээдийн хувьд итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг нотлох баримт/;</p> <p>13.1.3.ТШЗ-ны 15-д заасны дагуу бэлтгэсэн хувилбарт санал;</p> <p>13.1.4.ТШЗ-ны 16-т заасан ерөнхий шаардлагыг хангасан болохыг нотлох баримт бичиг;</p> <p>13.1.5.бараа нийлүүлэлтийн хуваарь;</p> <p>13.1.6.санал болгож буй бараа ТШЗ-ны 20-д заасан шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг;</p> <p>13.1.7.ТШЗ-ны 17, 18, 19-д заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангахыг нотлох баримт бичиг;</p> <p>13.1.8.ТШЗ-ны 22.5-д заасан тохиолдолд холбогдох тайлбар;</p> <p>13.2.Оролцогч өөрийн тендерийн бүх баримт бичиг, мэдээллийн хүчинтэй байдлыг нягтлах үүрэгтэй бөгөөд</p>

		үнэн зөвийг захиалагчийн өмнө хариуцна.
<b>14.Тендерийн жишиг маягт</b>	14.1.IV бүлэг дэх маягтын мэдээллийг хуулийн 21.1.3-т зааснаар цахим системд үүсгэсэн маягтад бөглөж, илгээнэ.	
<b>15.Хувилбарт санал</b>	15.1. Хуулийн 11.10-т заасан шаардлагад нийцэх хувилбарт саналыг ирүүлэх шаардлагатай бол өгөгдлийн хүснэгтэд заана.	
<b>16.Ерөнхий шаардлагыг магадлах баримт бичиг</b>	16.1.ТШЗ-ны 14.1-д заасны дагуу бөглөж ирүүлсэн V бүлгийн Маягт 1. 16.2.Хэрэв өгөгдлийн хүснэгтэд заасан бол хуулийн 7.1-д заасан ерөнхий нөхцөлийг магадлахтай холбоотой баримт бичиг. 16.3.Түншлэлийн гишүүн тус бүр ТШЗ-ны 16.1, 16.2-т заасан баримт бичиг ирүүлнэ.	
<b>17.Чадавхын болон туршлагын шаардлага тавих үндэслэл</b>	17.1.ТШЗ-ны 18, 19-д заасан чадавхын болон туршлагын шаардлага тавихад хуулийн 15 дугаар зүйлийг баримтална. 17.2.Хуулийн 15.2-т заасан цахим системээр дамжуулан шалгах боломжтой, олон нийтэд нээлттэй мэдээллийг нотлох баримтаар ирүүлэхгүй. 17.3.Түншлэлийн хувьд төлөөлөх эрх бүхий гишүүн, гишүүн хамтдаа ТШЗ 18, 19-д заасан чадавхын болон туршлагын шаардлагыг бүрэн хангасан байна.. 17.4.Түншлэлийн төлөөлөх эрх бүхий гишүүн ТШЗ-ны 18, 19-д чадавхын болон туршлагын шаардлагын 40-аас дээш хувийг, түншлэлийн гишүүн тус бүр 25 ба түүнээс дээш хувийг хангасан байна.	
<b>18.Санхүүгийн чадавхын шаардлага</b>	18.1.Хуулийн 16.5-д зааснаар оролцогч өгөгдлийн хүснэгтэд заасан санхүүгийн чадавхын шаардлага хангасан байна. 18.2.Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг шаардах бол хуулийн 16.2, 16.4-т заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана. 18.3.Оролцогчийн дансны мэдээлэл, түүний үлдэгдлийн талаар харилцагч банкнаас мэдэгдсэнээс бусад банк, санхүүгийн байгууллагын мэдэгдлийг оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд харгалзан үзэхгүй. Захиалагч энд зааснаас бусад асуудлаар харилцагч банкны тодорхойлолт ирүүлэхийг шаардахгүй. 18.4.Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойшхи өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар лавлагааг Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдээс цахим системээр авч, тендерт ирүүлэх ба уг асуудлаар банк, санхүүгийн байгуулагаас лавлагаа ирүүлэхийг шаардахгүй.	
<b>19.Техникийн чадавх болон туршлагын шаардлага</b>	19.1.Хуулийн 17.4-т зааснаар оролцогч өгөгдлийн хүснэгтэд заасан техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангасан байна. 19.2.Техникийн болон туршлагын чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг шаардах бол хуулийн 17.2-т заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана. 19.3.Бараа нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай зөвшөөрөл, эсхүл гэрчилгээ байгаа бол өгөгдлийн хүснэгтэд заана.	

<b>20.Санал болгож буй бараанд тавигдах шаардлага</b>	<p>20.1.ТШЗ-ны 6.1-д заасан тохиолдолд импортын барааны гарал үүслийг нотлох баримт бичиг тендерт ирүүлэхийг шаардахгүй.</p> <p>20.2.Санал болгож буй барааны техникийн тодорхойлолтод нийцсэн болохыг нотлох баримтыг тендерт ирүүлнэ.</p> <p>20.3.Нотлох баримт нь нийтлэл, зураг, үйлдвэрлэгчийн албан ёсны цахим хуудас хэлбэрээр байж болно.</p> <p>20.4.Хэрэв санал болгох бараа техникийн тодорхойлолтын аль нэг зүйлээс зөрүүтэй боловч шаардлага хангах бол түүнийг нотлох шаардлагатай.</p>
<b>21.Санал болгож буй барааны нийлүүлэлтийн дараах засвар, үйлчилгээ</b>	<p>21.1.Санал болгож буй барааны нийлүүлэлтийн дараах засвар, үйлчилгээтэй холбоотой өгөгдлийн хүснэгтэд заасан бол дараах баримт бичиг, мэдээллийг ирүүлнэ. Үүнд:</p> <p>21.1.1.санал болгож буй барааг тасралтгүй, горимын дагуу өгөгдлийн хүснэгтэд заасан хугацаанд ашиглахад шаардагдах сэлбэг хэрэгсэл, тусгай багаж болон бусад зүйлсийн жагсаалт, авах боломжтой хаяг, тэдгээрийн үнийн мэдээлэл;</p> <p>21.1.2.засвар, үйлчилгээг хэрхэн үзүүлэх тухай баримт болон мэдээлэл.</p> <p>21.1.3.гадаадын этгээдийн хувьд нийлүүлэлтийн дараах засвар, үйлчилгээг үзүүлэх үүргийг Монгол Улсын нутаг дэвсгэрт өөрөө, эсхүл өөрийн Монгол Улсад байгуулсан буюу байгуулах салбар, төлөөний газар, эсхүл бусад төлөөлөгч гүйцэтгэх тухай баримт.</p>
<b>22.Тендерийн үнэ</b>	<p>22.1.Үнийн санал дуудах ажиллагаа хаагдахад санал болгосон үнэ оролцогчийн тендерийн үнэ байна.</p> <p>22.2.Тендерийн үнэ гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байх эсэхийг өгөгдлийн хүснэгтэд заана. Өгөгдлийн хүснэгтэд тогтмол байхаар заасан тохиолдолд тохируулга хийх нөхцөлтэй тендер ирүүлсэн бол шаардлага хангаагүй гэж үзнэ. Өгөгдлийн хүснэгтэд үнийн тохируулга хийхийг зөвшөөрсөн тендер шалгаруулалтад тогтмол үнэ санал болгосон тендер ирүүлсэн нь тендерээс татгалзах үндэслэл болохгүй ба үнийн тохируулга нь гэрээний хэрэгжилтийн явцад тэгтэй тэнцүү гэж үзнэ.</p> <p>22.3.Бараа нийлүүлэх тендерт Олон улсын худалдааны танхимаас эрхлэн гаргадаг Олон улсын худалдааны нөхцөл /Incoterms/-ийг хэрэглэхдээ өгөгдлийн хүснэгтэд заагаагүй бол хамгийн сүүлийн хувилбарын Delivery Duty Paid /DDP/ нөхцөлийг бараа нийлүүлэлтийн хуваарын дурдсан газарт хүргүүлэхээр хэрэглэнэ.</p> <p>22.4.Үнийн задаргаанд тусгайлан тусгасан эсэхээс үл хамааран тендерийн үнэд хуулийн 27.13-т заасан зардлыг багтсанд тооцно.</p> <p>22.5.Хуулийн 21.5-д заасан тохиолдолд тендер шалгаруулалтын оролцогчийн тендерийн үнэ төсөвт өртгийн 80 хувиас доош бол уг үнэ нь бараа, ажил, үйлчилгээний хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхгүй талаар үндэслэл бүхий тайлбарыг тендерт ирүүлнэ.</p>
<b>23.Тендерийн валют</b>	23.1.Монгол Улсын олон улсын гэрээ болон хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол тендерийн үнийг Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх

	тухай хуулийн 4.1, 4.2-т заасны дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлнэ.
<b>24.Тендер хүчинтэй байх хугацаа</b>	<p>24.1.Оролцогч хуулийн 21.1.1-д заасны дагуу тендер нээснээс хойш өөрийн тендер хүчинтэй байх хугацааг ажлын 30-аас багагүй өдөр байхаар тендер илгээх маятад заана.</p> <p>24.2.Захиалагч хуулийн 28.8-д зааснаар тендер хүчинтэй байх хугацаа сунгах хүсэлт гаргасан бол оролцогч өөрийн ТШЗ-ны 24.1-д заасан хугацааг сунгаж болно.</p> <p>24.3.Оролцогч хугацааг сунгасан бол хуулийн 28.9-д зааснаар бичгээр мэдэгдэнэ.</p>
<b>Г.ТЕНДЕР ИЛГЭЭХ</b>	
<b>25.Тендер баталгаажуулах, илгээх</b>	<p>25.1.Тендерийг хуулийн 22 дугаар зүйлд заасны дагуу баталгаажуулан илгээнэ.</p> <p>25.2.Оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд тендерийг тоон гарын үсгээр баталгаажуулсан бол IV бүлэгт заасан маягтыг ТШЗ-ны 25.1-д зааснаар тамга, тэмдгээр баталгаажуулсан гэж үзнэ. Энэ тохиолдолд маягтыг баталгаажуулахтай холбоотой итгэмжлэл үйлдэх, хуулийн этгээдийн тамга, тэмдгээр баталгаажуулахыг шаардахгүй.</p> <p>25.3.Оролцогч хуулийн 22.5-д заасан хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийг ил болгохгүйгээр илгээх бол хуулийн 22.6.3-т заасан мэдэгдлийг IV бүлгийн Маягт 5-ын дагуу нууцлахгүйгээр ирүүлнэ.</p> <p>25.4.Хуулийн 22.6-д заасан баримт бичиг, мэдээллийг заавал ил болгож илгээх ба ТШЗ-ны 25.3-т заасан нь уг баримт бичгүүдэд хамаарахгүй. Захиалагч тухайн тендер шалгаруулалтад нэмэлтээр ил болгох баримт бичгийг өгөгдлийн хүснэгтэд заах ба уг баримт бичиг хүний эмзэг мэдээлэлд хамаарах бол мэдээллийн эзний зөвшөөрлийг авсны үндсэн дээр тендер илгээнэ.</p>
<b>26.Тендер хүлээн авах эцсийн хугацаа</b>	26.1.Тендер хүлээн авах эцсийн хугацааг өгөгдлийн хүснэгтэд заана. Огноо, цагийг цахим системийн серверийн цагаар тооцно.
<b>Д.ҮНИЙН САНАЛ ДУУДАХ АЖИЛЛАГАА</b>	
<b>27.Үнийн санал дуудах хугацаа</b>	<p>27.1.Хуулийн 34.6-д зааснаар үнийн санал дуудах ажиллагаанд бүртгүүлсэн сонирхогч этгээдийн тоо зарлалд заасан шаардлагатай тоонд хүрсэн тохиолдолд уг ажиллагаа ТШЗ-ны 26.1-д товлосон хугацаанаас нэг цагийн дотор эхэлнэ.</p> <p>27.2.Үнийн санал дуудах ажиллагаа хуулийн 34 дүгээр зүйлд заасан журмын дагуу явагдана.</p> <p>27.3.ТШЗ-ны 27.2-т заасан ажиллагаа урилгад заасан хугацаанд үргэлжилж хаагдана.</p>
<b>28.Тендер нээх</b>	28.1.ТШЗ-ны 27.3-т зааснаар хугацаа хаагдахад цахим систем оролцогч нарын санал болгосон эцсийн үнийг өсөх дарааллаар эрэмбэлэх ба захиалагч зөвхөн эхэнд эрэмбэлэгдсэн оролцогчийн тендерийг нээнэ.
<b>Е.ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ /ХЯНАН ҮЗЭХ</b>	
<b>29.Тендерийг шаардлагад нийцэх эсэхийг хянан үзэх</b>	29.1.Нээсэн тендерийг хуулийн 26 дугаар зүйлд заасан журам, ТШЗ-ны 13-т заасан тендерийн бүрдэл, холбогдох мэдээллийн сангаас илгээсэн мэдээлэл, оролцогч болон түүний тендерийн талаар авсан тайлбар, тодруулга, загвар, дээжид үндэслэн Сангийн сайдын баталсан зааврын дагуу хянан үзнэ.

	29.2.Тендерт ирүүлсэн аливаа баримт бичгийн үнэн зөв, хүчинтэй байдлыг шалгаж үзэх эрхтэй байна. 29.3.Эхэнд эрэмбэлэгдсэн оролцогчийн тендер шаардлагад нийцээгүй бол удаах эрэмбэлэгдсэн тендерийг хянан үзнэ.
<b>30.Тендерийн талаар тодруулга авах</b>	30.1.Тендерийг хянан үзэх явцад тодруулга авах шаардлагатай гэж үзвэл хуулийн 25 дугаар зүйлийг баримтална.
<b>Ё.МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ</b>	
<b>31.Мэдэгдэл хүргүүлэх</b>	31.1.Захиалагч хуулийн 28 дугаар зүйлд заасан шийдвэрийг хуулийн 24.1-д зааснаар ажлын 15 өдрийн дотор гаргаж, оролцогчдод мэдэгдэнэ.
<b>32.Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах</b>	32.1.Захиалагч ТШЗ-ны 8.1-д заасан гэрээний нөхцөлийн гэрээ баталгаажуулах маягтыг түүнд заасан зааврын дагуу эцэслэн нөхөж, оролцогчид хүргүүлнэ. 32.2.Шалгарсан оролцогч ТШЗ-ны 32.1-д зааснаар ирүүлсэн гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулан захиалагчийн тогтоосон хугацааны дотор хүргүүлнэ. 32.3.Захиалагч хуулийн 30.4-т зааснаар ажлын 10 өдрийн дотор гэрээг баталгаажуулаагүй бол гэрээ байгуулах шийдвэрт заасан нөхцөлөөр гэрээ байгуулсанд тооцогдоно.
<b>Ж.БУСАД</b>	
<b>33.Үнийн санал дуудах ажиллагааг дахин зарлах</b>	33.1.Захиалагч ТШЗ-ны 29.3-т зааснаар хянан үзээд бүх тендерээс татгалзсан бол шаардлага хангасан тендер ирээгүй шалтгааныг судалж, тендер шалгаруулалтыг дахин зарлах эсэх мэдээллийг хуулийн 28.1.3-т заасан шийдвэрт заана. 33.2.Үнийн санал дуудах ажиллагааг дахин зарлахад хуулийн 34.11-д заасныг баримтална.
<b>34.Тендер шалгаруулалтад гомдол гаргах</b>	34.1.Хууль болон Сангийн сайдын баталсан “Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам”-ын дагуу гомдлыг хянан шийдвэрлэнэ.

## II БҮЛЭГ.ӨГӨГДЛИЙН ХУСНЭГТ

<b>ТШЗ-НЫХОЛБОГОДОХЗААЛТ</b>	<b>А.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ</b>
<b>ТШЗ 1.1</b>	Захиалагчийн нэр: <b>Аймгийн Нэгдсэн Эмнэлэг</b>
<b>ТШЗ 1.1</b>	<p>Зарлалын дугаар: <b>ХӨАНЭ/20241211</b>          Тендер шалгаруулалтын нэр: <b>Бичиг хэрэг анхан шатны маягтын захиалга</b>          төсөл арга хэмжээний гүйцэтгэгч сонгох          Тендер шалгаруулалтын багцын тоо болон нэр: <b>Багцтай</b>  <b>Багц 1</b> : Эрүүл мэндийн сайдын 2019 оны 611 дүгээр тушаал          Б. Амбулатори поликлиникт хөтлөгдөх бүртгэлийн маягт-1,522,820          В. Стационаарт хөтлөгдөх бүртгэлийн маягт – 1,892,440          Г. Тусгай мэргэжлийн төв, төрөлжсөн мэргэшлийн эмнэлгүүдийн хөтлөгдөх бүртгэлийн маягт болон бусад – 4,763,100          2. ЭМС-ын тушаалаар батлагдсан хөтлөгдөх анхан шатны          Маягтууд - 3,675,260          4. Нэгдсэн эмнэлгийн захирлын тушаалаар батлагдсан – 206,400          5. Архив албан хэрэг хөтлөлт – 1,162,980</p>
<b>ТШЗ 2.1</b>	<p>Санхүүжилтийн эх үүсвэр: <b>Улсын төсөв</b>          Нийт төсөвт өртөг: <b>28,805,000 /багц1-13,223,000 /</b></p>
<b>Б.АГУУЛГА</b>	
<b>ТШЗ 9.2</b>	<p>Тендерийн баримт бичгийн талаар тодруулга авах хаяг: <b>Хөвсгөл Аймгийн Нэгдсэн эмнэлэг</b>          Хариуцсан ажилтан: <b>Эдийн засагч Ш.Даваахүү</b>          Хүлээн авагчийн нэр: <b>Хөвсгөл Аймгийн Нэгдсэн эмнэлэг</b>          Хаяг: <b>Мөрөн сум 8-р баг</b>          Утасны дугаар: <b>70382562</b>          Цахим шуудан: <b>mongolmongol612@gmail.com</b></p>
<b>ТШЗ 11.1</b>	Тендер ирүүлэх өмнө уулзалт зохион байгуулах эсэх: “ҮГҮЙ”
<b>В.ТЕНДЕР БЭЛТГЭХ</b>	
<b>ТШЗ 12.2</b>	Тендер шалгаруулалтын хэл: <b>Монгол хэл байна. Гадаад хэл дээрх бүх материалыг орчуулгын хамт ирүүлнэ.</b>
<b>ТШЗ 15.1</b>	Хувилбарт санал ирүүлэхийг: <b>“ЗӨВШӨӨРӨХГҮЙ”</b>
<b>ТШЗ 16.2</b>	<p>Ерөнхий шаардлагыг магадлахад шаардлагатай баримт бичиг:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Шүүхийн тусгай архивын лавлагааг цахимаар ирүүлнэ.</li> <li>- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолтыг цахим системээр ирүүлнэ.</li> </ul> <p>Тендерт оролцогч Худалдан авах ажиллагааны цахим систем (<a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>)-д өөрийн үндэсний тоон гарын үсэг ашиглан тендерийн нээлт хийхээс 3-аас доошгүй хоногийн өмнө нэвтрэн орж шүүхийн тусгай архивын лавлагаа авах хүсэлтийг илгээх бөгөөд Шүүхийн ерөнхий зөвлөл хянан үзэж лавлагаа цахимаар илгээдэг болохыг анхаарна уу.</p> <p>Жич: Дээрх шүүхийн лавлагаа авах зааварчилгаатай <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> цахим системийн хэрэглэгчийн хөтөч цэсээс танилцана уу.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Монгол Улсын хуулийн дагуу тухайн тендер нээсэн өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн өр төлбөргүй байх шаардлагатай. Нийгмийн даатгал, татварын тодорхойлолтыг ирүүлэх шаардлагагүй, “Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем” <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> болон “Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем”-ээр дамжуулан Татварын</li> </ul>

	<p>ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газрын цахим мэдээллийн сангаас шалгана.</p> <p>/Тендерт оролцогчийн ирүүлсэн татвар, нийгмийн даатгалын тодорхойлолтыг үнэлгээнд харгалзан үзэхгүй./</p>
ТШЗ 18.1	<p>Санхүүгийн чадавхын шаардлага:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Борлуулалтын орлогын хэмжээ: Сүүлийн 2 жил буюу 2022, 2023 онуудын борлуулалтын дундаж орлогын хэмжээ нь тухайн ажлын батлагдсан төсөвт өртийн үнийн дүнгийн 60 хувиас багагүй байх.</li> <li>- Сүүлийн 2 жилд ашигтай ажилласан байх. 2022, 2023 он</li> </ul> <p>Гэрээний үүргийн биелэлтийг хангах мөнгөн хөрөнгийн хэмжээ:</p> <p><b>Батлагдсан төсөвт өртийн 30 хувиас багагүй байх.</b></p> <p>Гэрээний үүргийн биелэлтийг хангах мөнгөн хөрөнгийн хэмжээг нийт дүнг дараах шалгуур үзүүлэлтүүдийн аль нэгээр эсвэл нийлбэрээр тус тус тодорхойлно. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>➤ Байгууллагын харилцагч банкин дахь дансны үлдэгдэл /Өөрийн гүйцэтгэсэн ажлын бодит орлого байх ба тухайн ажилд зориулан байршуулсан мөнгөн хөрөнгийг харгалзан үзэхгүй/</li> <li>➤ Тендерт оролцогч нь уг ажлыг гүйцэтгэхдээ зээл авах бол Харилцагч банкны баталгаажсан эрх /зохих журмын дагуу өмнө нь судлагдчихсан, тендерт шалгарсан тохиолдолд ямар нэгэн саадгүйгээр шууд олгох зээлийн мөнгөн дүн бүхий тодорхойлолт/ ирүүлнэ. Тендерт шалгарсан нөхцөлд судлаж, зохих журмын дагуу зээл олгох боломжтой гэсэн утга бүхий тодорхойлолтыг баталгаажсан эрх гэж үзэхгүй.</li> </ul> <p>Үнэт цаас, Засгийн газрын бонд болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан үнэт цааснууд</p>
ТШЗ 18.2	<p>Санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох баримт бичиг:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Харилцагч банкны тодорхойлолт;</li> <li>- Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойшхи өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан Монголбанкнаас зээлийн мэдээллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан компанийн лавлагаа ирүүлнэ. Дээрх тодорхойлолтыг гаргах эрх бүхий тусгай зөвшөөрөлтэй дараах 2 компанийн байна. Үүнд: “Бүрэн скор” ЗМС ХХК, (burenscore.mn) эсвэл (Титан Си ар Эм ЗМС ХХК) sainscore.mn</li> </ul> <p>Оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох санхүүгийн тайлангийн хугацаа: <b>2022, 2023 онуудын жилийн эцсийн санхүүгийн тайлан</b></p> <p>Тендерт оролцогч нь 2022, 2023 онуудын санхүүгийн тайланг өөрийн тендертээ хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд захиалагч Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр дамжуулан Сангийн яамны цахим санхүүгийн тайлангийн <a href="http://www.e-balance.mof.gov.mn">www.e-balance.mof.gov.mn</a> мэдээллийн системээс тендерт оролцогчдын сүүлийн 2 жилийн борлуулалтын орлого, болон бусад шаардлагатай мэдээллийг шалгана.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Жич: 2022, 2023 оны санхүүгийн тайлан e-balance цахим бүртгэлд шивэгдэж баталгаажсан байх шаардлагатай, санхүүгийн тайланг e-balance цахим бүртгэлд шивээгүй, баталгаажуулаагүй тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно.</li> </ul>
ТШЗ 19.1	<p>Техникийн чадавх болон туршлага: “Шаардана”</p> <ul style="list-style-type: none"> <li>- Компанийн танилцуулга ирүүлэх</li> <li>- Захирлын цахим иргэний үнэмлэхний эх хувиас сканердаж</li> </ul>

	<p>ирүүлэх</p> <ul style="list-style-type: none"> <li>- Нийлүүлэхээр санал болгож буй барааны техникийн үзүүлэлт /техникийн дэлгэрэнгүй тодорхойлолт/-ыг захиалагчийн шаардсан техникийн тодорхойлолттой харьцуулж хүснэгтээр баталгаажуулан ирүүлэх</li> </ul> <p><b>Анхааруулга:</b> Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцэхийг зүйл, заалт бүрээр нотлон харуулсан тайлбар, эсхүл тус тодорхойлолтын аль нэг зүйл заалтыг орхигдуулсан, зөрсөн боловч захиалагчийн тогтоосон техникийн тодорхойлолтын шаардлагатай дүйцэхүйц эсвэл түүнээс илүү шаардлага хангасан гэдгийг захиалагчид нотлон харуулна.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Нийлүүлэх барааны зургийг нэр төрөл бүрээр нэрийг нь бичиж өнгөтөөр, харагдах байдал бүрэн тодоор ирүүлэх</li> <li>- Нийлүүлэхээр санал болгож буй барааг Монгол Улсад нийлүүлэх эрх олгосон тухай үйлдвэрлэгчийн зөвшөөрөл, эсвэл тухайн байгууллагын албан ёсны дистрибьютер мөн болохыг гэрчлэх баримтыг орчуулгын хамт ирүүлэх. Энэхүү баримт бичиг нь албан ёсны, хүчин төгөлдөр байх мөн /Эрх бүхий байгууллагаас ирүүлсэн байх ба итгэмжлэлийг Монгол хэлрүү орчуулсан байна. Орчуулгын товчоо нь орчуулсан эх, орчуулгыг тус тус баталгаажуулсан байх/</li> <li>- Чанарын сертификат ирүүлэх</li> <li>- Нийлүүлэхээр санал болгох барааны ТШЗ-ны 8 дугаар зүйлд заасан гарал үүслийн мэдээллийг барааны үнийн задаргааны холбогдох хэсэгт бөглөж ирүүлнэ. /Гарал үүслийн улсыг үнэн зөв бичих шаардлагатай/</li> <li>- Тендерт оролцогчийг төлөөлөх эрх бүхий этгээд төлөөлөх эрхээ бусдад шилжүүлэх бол итгэмжлэл гаргаж ирүүлнэ. /Хуульд заасны дагуу итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд баталгаажуулсан тохиолдолд итгэмжлэл ирүүлэх шаардлагагүй/</li> <li>- Нийлүүлэгч нь техникийн тодорхойлолтод нийцсэн барааг захиалагч байгууллагын заасан газарт хүргэж, хүлээлгэж өгөх тухай албан бичиг ирүүлэх</li> <li>- Тендерт оролцогч нь техникийн тодорхойлолтыг хангаж байгаа эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч, эсвэл түүний төлөөлөгч барааг шалгаж, туршиж ажиллуулахыг зөвшөөрсөн мэдэгдэл ирүүлэх</li> <li>- Баталгаат хугацаа олгох албан бичиг ирүүлэх. /1 жилээс багагүй байх/</li> <li>- Тендерт ирүүлсэн материалыг гуравдагч этгээдүүдээс тодруулга авахад татгалзах зүйлгүй тухай албан бичиг ирүүлэх</li> </ul> <p><b>Ижил төстэй гэрээний туршлага: Шаардана”</b> 2022, 2023 онд гүйцэтгэсэн ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээний талаар IV бүлгийн МАЯГТ 2, МАЯГТ 3-ын дагуу бэлтгэж ирүүлнэ.</p> <p><b>Ижил төстэй гэрээний туршлага:</b> 2022, 2023 онуудын аль нэг жилд доод тал нь нэг удаа батлагдсан төсөвт өртгийн 30 хувиас багагүй үнийн дүнтэй захиалагчийн техникийн тодорхойлолтод заасан тоног төхөөрөмж нийлүүлсэн туршлагатай.</p> <p>Бараа, ажил үйлчилгээ үзүүлсэн гэрээ, хүлээлгэж өгсөн бараа, ажил, үйлчилгээний фото зургийг өнгөтөөр ирүүлэх. Тухайн барааг цаг хугацаанд нь чанартай нийлүүлсэн талаарх захиалагчийн тодорхойлолт авч эх хувиас сканердаж ирүүлэх.</p> <p><b>Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх шаардлага:</b> Оролцогч нь өөрийн болон түншлэлийн гишүүдийн хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх мэдээллийг IV бүлгийн Маягт 4-ын</p>
--	--

	<p>дагуу ирүүлнэ.</p> <p>Гэрээний үүргийн гүйцэтгэлийг хариуцах ажилтны нэр, боловсрол, мэргэжлийн ур чадварын шаардлага: <b>Шаардахгүй</b>.</p> <p>Гэрээний үүргийг гүйцэтгэхтэй холбоотой машин механизм, тоног төхөөрөмж, үйлдвэрлэлийн байрны шаардлага: <b>Шаардахгүй</b>.</p>
<b>ТШЗ 19.2</b>	<p>Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг нотлох баримт бичиг:</p> <ul style="list-style-type: none"> <li>- <b>Барааны үнийн задаргаа ба бараа нийлүүлэлтийн хугаарийг маягтын дагуу баталгаажуулан ирүүлнэ.</b></li> <li>- <b>Тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэ болон хугацаанд багтаан чанарын шаардлага хангасан барааг захиалагчид нийлүүлэх баталгааг албан бичгээр гаргаж ирүүлнэ.</b></li> </ul>
<b>ТШЗ 19.3</b>	<p>Бараа нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэхэд зөвшөөрөл, эсхүл гэрчилгээ шаардлагатай эсэх: <b>Шаардахгүй</b></p>
<b>ТШЗ 21.1</b>	<p>Санал болгож буй барааны нийлүүлэлтийн дараах засвар, үйлчилгээний талаарх мэдээлэл ирүүлэх эсэх: <b>“Тийм”</b></p> <p><b>Барааг техникийн тодорхойлолтын дагуу шаардлага хангаагүй бичиг хэрэг, маягт нийлүүлсэн тохиолдолд гарсан зөрчил дутагдалыг залруулга хийж буцаах болон нийлүүлэлтийн дараах засвар үйлчилгээ шаардлагатай.</b></p> <p>Санал болгож буй барааг тасралтгүй, горимын дагуу ашиглах хугацаа: <b>12 сар</b></p>
<b>ТШЗ 22.2</b>	<p>Оролцгчийн санал болгосон тендерийн үнийг гэрээний хэрэгжилтийн явцад: <b>“ТОХИРУУЛАХГҮЙ”</b></p>
<b>ТШЗ 22.3</b>	<p>Олон улсын худалдааны нөхцөлийг хэрэглэх эсэх: <b>“ТИЙМ” Incoterms 2020, DDP, Хөвсгөл аймгийн Нэгдсэн эмнэлгийн байранд</b></p>
<b>Г.ТЕНДЕР ИЛГЭЭХ</b>	
<b>ТШЗ 25.4</b>	<p>Оролцогчдод ил болох баримт бичгийн жагсаалт:</p> <ul style="list-style-type: none"> <li>- ТБОНӨХБАҮХАТухай хуулийн 7 дугаар зүйлд заасан оролцогчийн ерөнхий шаардлагууд</li> <li>- Тендер шалгаруулалтын баримт бичигт тусгасан маягтын дагуу илгээсэн мэдээлэл</li> </ul> <p>Тендер шалгаруулалтын баримт бичигт ил болгохоор заасан бусад баримт бичиг</p> <p>ТБОНӨХБАҮХАТхуулийн 22.5-д заасан үндэслэлээр ил болгохгүй баримт бичиг, мэдээлэл байгаа бол нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалтыг ТШЗ-ны IV бүлгийн ТШЗ-ны IV бүлгийн “Маягт 5” -ын дагуу бөглөж ирүүлнэ. Нууцалсан хууль зүйн үдэслэлийг оновчтой тодорхойлсон байна.</p>
<b>ТШЗ 26.1</b>	<p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь Огноо: <b>2024 оны 03 дугаар сарын 15-ны өдөр</b> Цаг: <b>11 цаг 15 минут</b></p>

### III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА



**НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН 2024 ОНД БИЧИГ ХЭРЭГ, АНХАН ШАТНЫ МАЯГТЫН ЗАХИАЛАХ**

<b>№</b>	<b>Маягтын нэр</b>	<b>Эрүүл мэндийн буртгэлийн маягтын дугаар</b>	<b>Хэмжээ</b>	<b>Хэмжих нэгж</b>	<b>Нийт тоо</b>	<b>Нэг бурийн унэ</b>	<b>Нийт</b>
<b>БАГЦ-1</b>							
<b>Эрүүл мэндийн сайдын 2019 оны 611 дүгээр тушаал</b>							
<b>Б. Амбулатори поликлиникт хөтөлгөдөх буртгалийн маягт</b>							
1	Хорт хавдрыг мэдээлэх хуудас	AM-5	A5	ш	300	80	24,000
2	Нас барсан тухай эмнэлгийн гарчилгээ	AM-7	A5	ш	115	80	9,200
3	Эмнэлгийн магадлагав	AM-8	A5	ш	5360	80	428,800
4	Эмийн жор	AM-9A	A6	ш	14000	30	420,000
5	Мансууруулах эмийн жорын маягт	AM-9B	A6	ш	1800	30	54,000
6	Эмнэлг хяналтын комиссоор орлогчдын буртгал	AM-12A	A4 50	дэвтэр	7	3200	22,400
7	Комиссын шийдвэр	AM-12B	A5	ш	3200	80	256,000
8	Жирэмээн эмэгтэйчүүдийн буртгал	AM-14A	A4 50	дэвтэр	5	3,200	16,000
9	Тэмбүүгийн халдвартай жирэмээн эмэгтэйн хяналтын буртгал	AM-14B	A4 50	дэвтэр	2	3,200	6,400
10	Амаржих газар /төрөх тасаг/ тэмбүү илрүүлах шинжилгээний буртгал	AM-14B	A4 50	дэвтэр	1	3,200	3,200
11	Үр хөндөлтийн түүх	AM-18	A4	ш	250	250	62,500
12	Үр хөндөлтийн буртгал	AM-19	A4 50	ш	1	3200	3,200
13	Серологийн шинжилгээний буртгал		A4 50	дэвтэр	16	3200	51,200
14	Даршилсан улаан эсийн буртгал		A4 50	дэвтэр	2	3200	6,400
15	Хөлдөөсэн шинэ сийвэзнийн буртгал		A4 50	дэвтэр	2	3200	6,400
16	К сийвэзнийн буртгал		A4 50	дэвтэр	2	3200	6,400
17	Криопрецепитат буртгал		A4 50	дэвтэр	2	3200	6,400
18	Ялтас эсийн өтгөрүүлэг буртгал		A4 50	дэвтэр	2	3200	6,400
19	Цагаан эсгүйжүүлсэн даршилсан улаан эсийн буртгал		A4 50	дэвтэр	2	3200	6,400
20	Цагаан эсгүйжүүлсэн улаан эсийн өтгөрүүлэг буртгал		A4 50	дэвтэр	2	3200	6,400
21	Улаан эсийн өтгөрүүлэг буртгал		A4 50	дэвтэр	2	3200	6,400
22	Угаасан улаан эсийн буртгал		A4 50	дэвтэр	2	3200	6,400
23	Гематологийн шинжилгээний буртгал		A4 50	дэвтэр	3	3200	9,600
24	Цус булгэнлтийн шинжилгээний буртгал		A4 50	дэвтэр	5	3200	16,000
25	Getein 1100 шинжилгээний буртгал		A4 50	дэвтэр	2	3200	6,400
26	Клинич химийн шинжилгээний буртгал		A4 50	дэвтэр	3	3200	9,600
27	Элзгний В, С вирусийн маркерийн шинжилгээний буртгал /Донор/		A4 50	дэвтэр	3	3200	9,600
28	ХДХВ, БЗДХ илрүүлах шинжилгээний буртгал /Донор/		A4 50	дэвтэр	3	3200	9,600
29	Нян судлалын лабораторийн шинжилгээний хариуны маягт-өслөвөр	AM-22K	A6	ш	200	70	14,000
30	Нян судлалын шинжилгээний буртгал	AM-23-5	A4	дэвтэр	39	80	3,120
31	Саргээн засах эмчилгээний буртгал	AM-25B	A4 50	дэвтэр	2	3200	6,400
32	Осол гэмтлийн тохиолдолыг буртгах хуудас	AM-33	A4	ш	300	80	24,000
	дун						1,522,820
<b>В. Стационарт хөтөлгөдөх буртгалийн маягт</b>							
33	Эмчлүүлэгчийн хэрглэсэн эмийн хуудас	СТ-1,2 Хавсралт 1	A4	ш	12000	90	1,080,000
34	Зрчимт эмчилгээний хяналтын хуудас	СТ-1,2 Хавсралт 4	A3	ш	300	500	150,000
35	Мэс засал/мэс ажилбар хийлгэх тухай зөвшөөрлийн хуудас	СТ-1,2 Хавсралт 8	A4	ш	100	80	8,000
36	Амь нас/зруул мэндэд эрсдэлтэй тусламж үйлчилгээ үзүүлэх зөвшөөрлийн хуудас	СТ-1,2 Хавсралт 9	A4	ш	100	80	8,000
37	Өөрийн хусалтээр эмнэлгээ гарах тухай зөвшөөрлийн хуудас	СТ-1,2 Хавсралт 10	A4	ш	50	80	4,000

38	Өөрийн хүснэгтээр эруул мэндийн тусламж үйлчилгээ авах тухай зөвшөөрлийн хуудас	СТ-1,2 Хавсралт 11	A4	ш	100	80		8,000
39	Эруул мэндийн тусламж үйлчилгээнээс татгалзсан тухай мэдүүлэг	СТ-1,2 Хавсралт 12	A5	ш	100	70		7,000
40	Терелтийн буртгэл	СТ-5	A4 50	дэвтэр	10	3200		32,000
41	Эхийн амрах байраар үйлчлүүлэгчдийн буртгэл	СТ-6	A4	дэвтэр	1	3200		3,200
42	Нярайн эрчимт эмчилгээний хяналтын хуудас	СТ-7 Хавсралт 1	A4	ш	300	80		24,000
43	Нярай хүүхдийн буртгэл	СТ-8	A4 50	дэвтэр	3	3200		9,600
44	Нярайн вакцин хийсэн тухай буртгэл	СТ-9	A4 50	дэвтэр	3	3200		9,600
45	Эмчлүүлэгчийг эмнэлэг /сувилалд/ хүлээн авсан буртгэл	СТ-13А	A4 50	дэвтэр	5	3200		16,000
46	Яаралтай тусламж, үйлчилгээ үзүүлэгчдийн буртгэл	СТ-13Б	A4 50	дэвтэр	50	3200		160,000
47	Эмчлүүлэгчдийн өдөр тутмын тооцооны буртгэл	СТ-14	A4 50	дэвтэр	18	3200		57,600
48	Цус, цусан бүтээгдэхүүн сэлбэлтэй холбоотой урвал, хүндэрлийн буртгэл	СТ-21	A4 50	дэвтэр	4	3200		12,800
49	Цус цусан бүтээгдэхүүн захиалсан ба хүлээн авсан буртгэл	СТ-22	A4 50	дэвтэр	11	3200		35,200
50	Алсын дуудлагын буртгэл	СТ-26	A4 50	дэвтэр	1	3200		3,200
51	Тусгай хог хаягдлын устгалын буртгэл	СТ-28	A4	дэвтэр	3	3200		9,600
52	Эмнэлгийн зөвлөн здлэлд хийсэн халдвартгуйтгэл, угаалга ариутгалд хүлээн авч, олгосон буртгэл	СТ-30	A4 50	дэвтэр	14	3200		44,800
53	Ариутгалд багаж материал хүлээн авч, олгосон буртгэл	СТ-31	A4 50	дэвтэр	45	3200		144,000
54	Амигуулах тусламжийн хуудас	СТ-33	A4	ш	200	80		16,000
55	Гемодиализийн хяналтын карт	СТ-34	A4	ш	10	300		3,000
56	Гемодиализийн сеансын дэвтэр		A4 50	дэвтэр	12	3200		38,400
57	Хэвлэлийн гемодиализийн хуудас		A4	ш	18	80		1,440
58	Халдварт өвчин, хамшинж, сзионгийн тохиолдолыг мэдээлэх хуудас	AM-2	A5	ш	100	70		7,000
	Дун							1,892,440

Г. Тусгай мэргэжлийн төв, төрөлжсөн мэргэшлийн эмнэлгүүдийн хөтөлгөх буртгэлийн маягт болон бусад

59	Сурьеэстэй евчтений эмчилгээ хяналтын карт	СҮ-2	A5	ш	300	350		105,000
60	Сурьеэгийн үүсгэгч илрүүлэх шинжилгээний буртгэл	СҮ-5	A4/	дэвтэр	2	3200		6,400
61	Түрхэц ёсгеверлэх XPERT MTB/RIE шинжилгээний буртгэл	ЭТС-3	A4 50	дэвтэр	2	3200		6,400
62	БЗДХ-ын хавьталь судлалын буртгэл	БЗДХ-1	A4/	дэвтэр	2	3200		6,400
63	Серологийн шинжилгээний буртгэл	БЗДХ-3	A4 50	дэвтэр	16	3200		51,200
64	Тэмбүүгийн үүсгэгч илрүүлэх шинжилгээний хариуны маягт	БЗДХ-4	A5	ш	3500	70		245,000
65	ХДХВ-ийн халдварт илрүүлэх шинжилгээний хариуны маягт	БЗДХ-5	A5	ш	3500	70		245,000
66	Нян судлалын лабораторийн шинжилгээний хариуны маягт	БЗДХ-6/ар, ёвтугий/	A5	ш	3000	70		210,000
67	Амьд сорьцын шинжилгээний буртгэл	ЭС-0	A4	дэв	2	3200		6,400
68	Амьд сорьцын шинжилгээний хуудас	ЭС-1А	A5	ш	2000	90		180,000
69	Цогцыг хүлээн авсан олгосон буртгэл	ЭС-2	A4	дэв	1	3200		3,200



70	Эмгэг судалын шинжилгээний буртгал	ЭС-3	A4	дэв	1	3200	3,200
71	Эсийн шинжилгээний буртгал	ЭС-4	A4	дэв	17	3200	54,400
72	Умайн хүзүүний эсийн шинжилгээний хуудас	ЭС-4Б	A4	ш	1500	80	120,000
73	Эмэгтэйчүүдийн эдийн шинжилгээний хуудас	ЭС-1В	A4	ш	500	80	40,000
74	Хими эмчилгээнд хамрагдсын буртгал хяналт		A4 50	дэв	3	3200	9,600
75	Хорт хавдрын эрсдэлт хүчин зүйлсийн мэдээлэх хуудас		A4	ш	300	80	24,000
76	Донорын эмчийн үзлэгийн буртгал		A4	дэвтэр	5	3200	16,000
77	Цусны неец зохицуулах нэгжийн буртгал	ЦТ-0	A4	дэвтэр	5	3200	16,000
78	Цус цусан бүтээгдэхүүн салбасан протокол	ЦТ-2 /ар өвөргүй/	A4	ш	200	80	16,000
79	Цус цусан бүтээгдэхүүн захиалах маягт	ЦТ-3 /ар өвөргүй/	A5	ш	50	70	3,500
80	Донорт илэрсан серег урвал хүндрэлийг бурттан мэдээлэх маягт	ЦТ-4	A5	ш	100	90	9,000
81	Хаягдал цус, цусан бүтээгдэхүүн шинжилгээний сорьцын устгалын буртгал	ЦТ-5	A4 50	дэвтэр	2	3200	6,400
82	Цус сэлбэлттэй холбоотой урвал хүндрэлийн шалтгавын судлах маягт	ЦТ-6	A4	ш	50	80	4,000
83	Цусны АВО, резус булаг тодорхойлох шинжилгээний буртгал	ЦТ-14	A4	дэвтэр	11	3200	35,200
84	Хувийн тохироо тодорхойлох шинжилгээний карт	ЦТ-16	A4	дэвтэр	4	3200	12,800
85	Цус цусан бүтээгдэхүүн олгох маягт	ЦТ-18	A4	ш	1000	80	80,000
86	Эмнэлэгт олгосон цус цусан бүтээгдэхүүний буртгал		A4 50	дэвтэр	15	3200	48,000
87	Цусны донорын эрүүл мэндийн карт	ЦТ-2	A5 12	дэвтэр	1000	3200	3,200,000
	дун						4,763,100

2. ЭМС-ын тушаалаар батлагдсан хетлэгдех анхан шатны маягтүүд

88	Мансуруулах сэтгэц нелеөөт эм, тарианы орлого, зарцуулалтын буртгал	ЭМС-ын 2015 оны А/68 дугаар тушаал	A4 50	дэвтэр	19	3200	60,800
89	Мансуруулах сэтгэц нелеөөт эм, тарианы устгалын буртгал	ЭМС-ын 2015 оны А/68 дугаар тушаал	A4 50	дэвтэр	4	3200	12,800
90	Жирамсэн эмэгтэйчүүдийн тэмбүүгийн буртгал	ЭМС-ын 2017 оны А/305 дугаар тушаал	A4 50	дэвтэр	1	3200	3,200
91	Мэс ажилбарын дараах шархны халдвартыг шинж тэмдэгзэр тандах хуудас	ЭМС-ын 2019 оны А/539 дүгээр тушаалын 2 дугаар хавсралт	A5	ш	125	80	10,000
92	Нярайг халдвартыг шинж тэмдэгзэр тандах тандалтын хуудас	ЭМС-ын 2019 оны А/539 дүгээр тушаалын 6 дугаар хавсралт	A5	ш	500	80	40,000
93	Төрсний дараах эхийн халдвартыг тандах хуудас		A5	ш	500	80	40,000
94	Нянгийн эсрэг змийн тэсвэржилтийн дүнг мэдээлэх буртгал	ЭМС-ын 2019 оны А/539 дүгээр тушаалын 2 дугаар хавсралт	A/4 50	дэвтэр	2	3200	6,400
95	Судасны гуурстай үйлчлүүлэгчдийг халдвартыг шинж тэмдэгзэр тандалтын хуудас	ЭМС-ын 2019 оны А/539 дүгээр тушаалын 3 дугаар хавсралт	A5	ш	1500	70	105,000
96	Шээлгүүртэй холбоотой шээсний замын халдвартын тандалтын буртгал	ЭМС-ын 2019 оны А/539 дүгээр тушаалын 4 дугаар хавсралт	A4 50	дэвтэр	20	3200	64,000

97	Судасны гуурстай үйлчлүүлэгчдийн дунд ушигын хатгалгааг тандалтын бүртгэл	ЭМС-ын 2019 оны А/539 дүгээр тушвалын 5 дугаар хавсралт	A4 50	дэвтэр	30	3200		96,000
98	Амьсгалын аллараттай үйлчлүүлэгчдийг амьсгалын замын халдвартын шинж тэмдэгзэр тандах хуудас	ЭМС-ын 2019 оны А/539 дүгээр тушвалын 5 дугаар хавсралт	A4	дэвтэр	20	3200		64,000
99	Амбулаторын хийгдэх ажилбарын хяналтын хуудас №5	2013 оны А/177 дугаар тушвал	A4	ш	300	80		24,000
100	Кесар мэс засалд орох вэчтэний аюулгүй байдлын шалгuur хуудас	2019 оны А/518 дугаар тушвал	A4	ш	300	80		24,000
101	ЭТҮХХ-ын тандалтын бүртгэлийн дэвтэр /уюн зүү, шээлгүүр, мэс ажилбар/	ЭМС-ын 2019 оны А/539 дүгээр тушвал	A5	дэвтэр	9	3200		28,800
102	ЭТҮХХ-ыг шинж тэмдэгзэр тандах хуудас	ЭМС-ын 2019 оны А/539 дүгээр тушвалын 7 дугаар хавсралт	A5	ш	500	70		35,000
103	ЭТҮХХ-ын тандалтын бүртгэл	ЭМС-ын 2019 оны А/539 дүгээр тушвалын 7 дугаар хавсралт	A4	дэвтэр	16	3200		51,200
104	Цочмог халууралт, тууралтат хам шинж сэжигтэй тохиолдлын тархвар судалгваны хуудас	ЭМС-ын 2018 оны А/527 дугаар тушвал	A4	ш	100	70		7,000
105	Цочмог халууралт, цэврүүт тууралтат хам шинж сэжигтэй тохиолдлын тархвар судалгваны хуудас		A4	ш	150	70		10,500
106	Хоол хүнсээр дамжих ёвчний тархвар судалгваны хуудас		A4	ш	150	70		10,500
107	Суулгаттай халдвартын хам шинж сэжигтэй тохиолдлыг мэдээлэх хуудас		A4	ш	150	70		10,500
108	Антибиотикийн сорилын дэвтэр	ЭМС-ын 2019 оны А/539 дүгээр тушвал	A4 50	дэвтэр	3	3200		9,600
109	Хатгалтыг мэдээлэх бүртгэл	ЭМС-ын 2019 оны А/539 дүгээр тушвалын 7 дугаар хавсралт	A4 50	дэвтэр	19	3200		60,800
110	ЗА-ны халдвартын эрсдэлт хүчин зүйлд өртөлтийг мэдээлэх бүртгэл	ЭМС-ын 2019 оны А/539 дүгээр тушвалын 3 дугаар хавсралт	A4 50	дэвтэр	1	3200		3,200
111	Эмнэлгийн хог хаягдлын бүртгэл	ЭМС-ын 2017 оны А/505 дугаар тушвал	A4 50	дэвтэр	9	3200		28,800
112	Аюултай хог хаягдлын бүртгэл		A4 50	дэвтэр	28	3200		89,600
113	Аюултай хог хаягдлын устгалын бүртгэл		A4 50	дэвтэр	5	3200		16,000
114	Халдвартай хог хаягдлыг уураар халдвартай хог хаягдлыг бүртгэл		A4 50	дэвтэр	4	3200		12,800
115	Ариутгалын тасагт багаж материалыг хулээн авсан бүртгэл	ЭМС-ын 2019 оны А/539 дүгээр тушвалын 2 дугаар хавсралт	A4 50	дэвтэр	6	3200		19,200
116	Ариутгалын бүртгэл хяналт	ЭМС-ын 2019 оны А/539 дүгээр тушвалын 2 дугаар хавсралт	A4 50	дэвтэр	6	3200		19,200
117	Ариутгасан багаж материалыг тасагт хулзэлгэн өгсөн бүртгэл	ЭМС-ын 2019 оны А/539 дүгээр тушвалын 2 дугаар хавсралт	A4 50	дэвтэр	19	3200		60,800
118	Ариутгалын тасагт бор материал балтгэсэн өдөр тутмын бүртгэл	ЭМС-ын 2019 оны	A4 50	дэвтэр	8	3200		25,600
119	Зөвлөн здлэлийн бүртгэлийн журнал		A4 50	дэвтэр	12	3200		38,400
120	Тасгийн угайлын бүртгэл		A4 50	дэвтэр	12	3200		38,400

121	Ариутгалын бодисын бүртгэл	A/539 дүгээр тушаал	A4 50	дэвтэр	12	3200		38,400
122	Химиийн халдвартгүйтгэлийн бүртгэл		A4 50	дэвтэр	53	3200		169,600
123	Халдвартгүйтгэлийн бодисын зарцуулалтын тооцоо		A4 50	дэвтэр	25	3200		80,000
124	Хоолны бүртгэл	ЭМС-ын 2018 оны A/16 дугаар тушаал	A4 50	дэвтэр	38	3200		121,600
125	Хоолны дээжийн бүртгэл		A4 50	дэвтэр	10	3200		32,000
126	Хоолны материалын цэс		A5	ш	500	70		35,000
127	Мэс заслын хяналтын хуудас	2019 оны A/518 тушаал хавсралт 3	A4	ш	500	80		40,000
128	Мэс заслын боолтын бүртгэл		A4 50	дэвтэр	20	3200		64,000
129	Мэс засал хагалгааны бүртгэл		A4 50	дэвтэр	8	3200		25,600
130	Мэс заслын сувилгачийн хяналтын хуудас		A4	ш	2500	80		200,000
131	Эрдээлийн үнэлгээнд орсон үйлчлүүлэгчдийн бүртгэл	ЭМС-ын 2022 оны A/139 дүгээр тушаал	A4 50	дэвтэр	2	3200		6,400
132	Насанд хүрэгчдийн үнэлгээ		A4	ш	1500	70		105,000
133	Үнэгүй эмийн хуудас		A5	ш	1500	70		105,000
134	Үнэгүй эм олгосон бүртгэл	ЭМС-ын 2022 оны A/407 дугаар тушаал	A4 50	ш	4	90		360
135	Байнгын асаргаа шаардлагатай ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ба иргэний тодорхойлолт		A5 12	ш	400	70		28,000
136	Амбулатори, поликлиникээр үнэ төлбөргүй олгох хуудас		A5 12	ш	600	70		42,000
137	Вакцины орлого, зарлагын өдөр тутмын бүртгэл /Саа/	ЭМС-ын 2019 оны A/611 дүгээр тушаал ΘЭ-5г	A4 50	дэвтэр	1	3200		3,200
138	Вакцины орлого, зарлагын өдөр тутмын бүртгэл /БЦЖ/		A4 50	дэвтэр	1	3200		3,200
139	Вакцины орлого, зарлагын өдөр тутмын бүртгэл /ВГВ/		A4 50	дэвтэр	1	3200		3,200
140	Вакцины орлого, зарлагын өдөр тутмын бүртгэл /тариуп/		A4 50	дэвтэр	1	3200		3,200
141	Вакцины орлого, зарлагын өдөр тутмын бүртгэл /Сайн дур/		A4 50	дэвтэр	1	3200		3,200
142	Вакцины хадгалалтыг хянах тэмдэглэл		A4 50	дэвтэр	1	3200		3,200
143	Хүүхдийн урьдчилан сэргийлэх тарилгын гэрчилгээ	ЭМС-ын 2019 оны A/611 дүгээр тушаал ΘЭ-7	A5	ш	1500	500		750,000
144	Ургийн зүрхний бичлэгийн бүртгэл	ЭМС-ын 2019 оны A/611 дүгээр тушаал	A4 50	дэвтэр	12	3200		38,400
145	Яаралтай тусламжийн эм, тарианы орлого, зарлага бүртгэл	ЭМС-ын 2019 оны A/294, 2021 оны A/814 дүгээр тушаал	A4 50	дэвтэр	21	3200		67,200
146	Эм тарианы зарцуулалтын бүртгэл		A4 50	дэвтэр	49	3200		156,800
147	Амигуулах сурь тусламжийн цомгийн зарцуулалтын бүртгэл		A4 50	дэвтэр	2	3200		6,400
148	Түргэн тусламжийн эмч нарын эм, тарианы зарцуулалтын дэвтэр		A4 50	дэвтэр	8	3200		25,600
149	Дуудлагын эмч нарын ажил хүлээнцэх дэвтэр		A4 50	дэвтэр	2	3200		6,400
150	Дуудлага хүлээн авах эмч нарын ажил хүлээнцэх дэвтэр		A4 50	дэвтэр	2	3200		6,400
151	Бага эмч нарын ажил хүлээнцэх дэвтэр		A4 50	дэвтэр	2	3200		6,400
152	Түргэн тусламжийн явуулын бүх үйлчилгээг бүртгэх дэвтэр		A4 50	дэвтэр	30	3200		96,000
153	Ойрын дуудлагын бүртгэл		A4 50	дэвтэр	3	3200		9,600
154	Амь тэнссэн үеийн тусламж үйлчилгээний бүртгэл		A4 50	дэвтэр	1	3200		3,200
155	Эрэмблэн ангилах, мэдээний дэвтэр		A4 50	дэвтэр	2	3200		6,400
156	Яаралтай тусламжийн эм, тарианы зарцуулалтын бүртгэл		A4 50	дэвтэр	7	3200		22,400

157	Эмнэлгийн хэрэгслийн зарцуулалтын бүртгэл		A4 50	дэвтэр	22	3200		70,400
158	Эрт сэргэмжлүүлэх үнэлгээний хуудас		A5	ш	100	70		7,000
159	Дурангийн бүртгэл	СТ-2, хавсралт 12	A4 50	дэвтэр	4	3200		12,800
160	Тодосгогчтой КТГ-ийн бүртгэл	СТ-2, хавсралт 12	A4 50	дэвтэр	4	3200		12,800
161	Тодосгогчгүй КТГ-ийн бүртгэл	СТ-2, хавсралт 12	A4 50	дэвтэр	4	3200		12,800
162	Дуран хадгалах шүүгээний бүртгэл	СТ-2, хавсралт 12	A4 50	дэвтэр	10	3200		32,000
163	Дурангийн хяналтын хуудас	СТ-2, хавсралт 12	A4 50	ш	700	80		56,000
164	Давсаг дурандсан бүртгэл	СТ-2, хавсралт 12	A4 50	дэвтэр	1	3200		3,200
165	Уян дурангаар гадны биет авсан бүртгэл	СТ-2, хавсралт 12	A4 50	дэвтэр	1	3200		3,200
166	Дуран угаах машины бүртгэл	СТ-2, хавсралт 12	A4 50	дэвтэр	8	3200		25,600
	дүн							3,675,260

4. Нэгдсэн эмнэлгийн захирлын тушаалаар батлагдсан

167	Эмч нарын хамтарсан үзлэгийн хуудас		A4	ш	800	80		64,000
168	Жижүүр эмч нарын мэдээний дэвтэр		A4	дэвтэр	12	3200		38,400
169	Жижкуурийн эмчийн мэдээний дэвтэр		A4	дэвтэр	12	3200		38,400
170	Ижил мэргэжилтэний үнэлгээний хуудас		A4	ш	200	80		16,000
171	Түнхний ЭХО-ний бүртгэл		A4	дэвтэр	3	3200		9,600
172	Эмнэлзүйн хэлэлцүүлгийн бүртгэл		A4	дэвтэр	6	3200		19,200
173	Сувилахуйн хамтарсан үзлэг		A4	дэвтэр	4	3200		12,800
174	Сувилахуйн хамтарсан үзлэгийн маягт		A4	ш	100	80		8,000
	дүн							206,400

5. Архив албан хэрэг хөтөлөлт

175	Эд хөрөнгийн тооллогын бүртгэл		A4 50	дэвтэр	10	3200		32,000
176	Орлогын маягтын бүртгэл		A4 50	дэвтэр	3	3200		9,600
177	Цагийн бүртгэл		A4 50	дэвтэр	40	3200		128,000
178	Илүү цагийн бүртгэлийн дэвтэр		A4	дэвтэр	12	3200		38,400
179	Техник ашиглалтын паспорт		A5 16	дэвтэр	50	3200		160,000
180	Архивын лавлагааны бүртгэлийн дэвтэр		A4	дэвтэр	3	3200		9,600
181	Архивын гэрчилгээ		A5	ш	50	1500		75,000
182	Тушаалын бүртгэл А		A4 50	дэвтэр	4	3200		12,800
183	Тушаалын бүртгэл Б		A4 50	дэвтэр	4	3200		12,800
184	Ирсэн бичгийн бүртгэл		A4 50	дэвтэр	3	3200		9,600
185	Явсан бичгийн бүртгэл		A4 50	дэвтэр	3	3200		9,600
186	Өргөдөл гомдолын бүртгэл		A4/50	дэвтэр	2	3200		6,400
187	Баримт бичиг хүлээлцэх дэвтэр		A4 50	дэвтэр	1	2060		2,060
188	Тушаалын бланк		A4	ш	1000	110		110,000
189	Албан бичгийн бланк		A4	ш	500	110		55,000
190	Албан бичгийн бланк		A5	ш	1500	70		105,000
191	Шаардах хуудас		A/5	дэвтэр	20	3200		64,000
192	Жолоочийн тооцооны хуудас		A4/50	ш	434	80		34,720
193	Эмийн захиалаг		A/4	ш	1000	90		90,000
194	Агуулахын бүртгэл		A/4 50	дэвтэр	4	3200		12,800
195	Бэлэн мөнгөний орлого баримт хортой		A/6	дэвтэр	50	3200		160,000
196	Бэлэн мөнгө хүссэн өргөдөл		A/4	дэвтэр	4	3200		12,800
197	Бараа материалын орлогын баримт		A/5	дэвтэр	4	3200		12,800
	дүн							1,162,980
	нийт дүн							13,223,000

БАГЦ-2 Бичиг хэрэг хэрэгсэл

1	Принтерийн хор		Самсунг 101S	ш	25	65000		1,625,000
2	Принтерийн хор цэнэлэгч		Самсунг 101S	ш	17	13000		221,000

3	Принтерийн хор		HP2035	ш	19	65000	1,235,000
4	Принтерийн хор цэнэлэгч		HP2036	ш	40	13000	520,000
5	Принтерийн хор		HP202	ш	5	450000	2,250,000
6	Пос машины цаас			боодол	60	15000	900,000
8	Фото цаас			ш	200	13000	2,600,000
10	2р цаас	A4		ш	700	80	56,000
11	Баримтын хавтас	A3		ш	250	1300	325,000
12	Бичгийн цаас	A4		боодол	300	19500	5,850,000
	<b>дүн</b>						<b>15,582,000</b>
	<b>нийт дүн</b>						<b>28,805,000</b>

БАТАЛСАН: ЗАХИРАЛ Г.ОЮУНЖАРГАЛ

СУДАЛГАА ТӨСӨВ ГАРГАСАН:

СЭЗАЛБАНЫ ДАРГА

ЧАБХСХ-ЫН АЛБАНЫ ДАРГА

ДААТГАЛЫН ЭДИЙН ЗАСАГЧ

Л.НАСАНЖАРГАЛ

Г.МӨНХТҮВШИН

Ш.ДАВААХҮҮ

## Техникийн тодорхойлолт

Санал болгох бараа нь дор дурдсан техникийн тодорхойлолт, стандартад нийцсэн байна. Хуулийн 26.8-д зааснаар эсхүл түүнтэй дүйцэх” гэсэн тодотгол хэрэглэсэн техникийн тодорхойлолтод өөр бараа санал болгосон оролцогч техникийн тодорхойлолтод заасантай дүйцэх болохыг ТШЗ 20.2-т заасан баримт бичгээр нотолсон бол техникийн тодорхойлолтыг хангасан гэж үзнэ.

Барааны нэр: .....

№	Захиалагчийн техникийн тодорхойлолт  (Тухайн барааны үзүүлэлт тус бүрийг дор жагсааж бичих ба хэрвээ чанарын баталгаамт хугацаа шаардах бол бичнэ үү.)	Санал болгож буй техникийн тодорхойлолт  (Зөвхөн санал болгож буй барааны техникийн тодорхойлолтыг бичнэ үү.)	Тайлбар  (дээрх үзүүлэлтийг нотлох баримт бичиг болон танилцуулгыг хавсаргана)
1			
2			
3			
...			

[Үнэлгээний хороо худалдан авах ажиллагааны цахим систем /www.tender.gov.mn/-д нийтэлсэн техникийн тодорхойлолтын жишиг нөхцөл, стандарт, загварыг баримтлан техникийн тодорхойлолтыг боловсруулна.]  
Зураг, төсөл

Шаардлагатай бол барааны эскиз, зургийг хавсаргана.

## БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

[Захиалагч доорх хүснэгтийн 1-6 хүртэлх баганыг, төндөрт оролцогч 7 дугаар баганыг бөглөнө ]

№	Барааны нэр	Тоо хэмжээ	Хэмжих нэгж, тун	Барааг хүргэх эцсийн цэг	Бараа нийлүүлэх хугацаа		
					Захиалагч бараа хүлээн авах хугацаа (эхлэх болон дуусах хугацаа)	Нийлүүлэгчийн санал болгох хугацаа (Оролцогч энэ баганыг бөглөнө)	7
1	2	3	4	5	6		
1	Бүртгэлийн маягтууд	Захиалсан тоогоор	ширхэг	Хөвсгөл аймгийн Нэгдсэн эмнэлэг	2024.03.06-ээс 2024.12.01	[6 дугаар баганад заасан хугацаанд багтаан нийлүүлэхээр санал болгож буй хугацааг бичих]	

#### **IV БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ЖИШИГ МАЯГТ**

Захиалагч энэ бүлэгт оролцогчийн бөглөх шаардлагатай бүх маягтыг тусгана.

**Маягтын жагсаалт:**

<b>Маягт 1: Тендер илгээх маягт .....</b>	<b>28</b>
<b>Маягт 2: Ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээний мэдээлэл.....</b>	<b>29</b>
<b>Маягт 3: Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл .....</b>	<b>29</b>
<b>Маягт 4: Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл .....</b>	<b>29</b>
<b>Маягт 5: Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт .....</b>	<b>29</b>

## Маягт 1: Тендер илгээх маягт

[огноо]

### [Захиалагч байгууллагын нэр]

Манай [оролцогчийн нэр] нь танай байгууллагаас зарласан [тендер шалгаруулалтын нэр, дугаар] тендер шалгаруулалтын үнийн санал дуудах ажиллагаанд эцсийн санал болгосон үнээр тендерийн баримт бичигт заасан хуваарийн дагуу бараа нийлүүлэхээр, дор дурдсан нөхцөлийг баталж энэхүү тендер (цаашид “тендер” гэх)-ийг хүргүүлж байна. Үүнд:

1. Тендерийн баримт бичиг, түүнд заасан гэрээний нөхцөл (гэрээний ерөнхий нөхцөл, тусгай нөхцөл, гэрээ баталгаажуулах маягт)-тэй танилцаж, бүрэн хүлээн зөвшөөрч тендер шалгаруулалтад оролцсон.
2. Оролцогч, түүний түншлэлийн гишүүн худалдан авах ажиллагаанд оролцох холбоотой хуулиар хориглосон нөхцөлд хамаarahгүй бөгөөд үүний дотор дараах нөхцөлийг гэрчилж байна:
  - 2.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй;
  - 2.1. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, түүний эцсийн өмчлөгч, хөрөнгө эзэмшигч, хамтрагч, эсхүл эдгээрийг гүйцэтгэж байгаа хувиараа аж ахуй эрхлэгч нь Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт заасан албан тушаал эрхэлж байсан болон эрхэлж байгаа хүн, эсхүл түүнтэй хамаарал бүхий этгээд биш;
  - 3.1. Захиалагчийн удирдлага, хяналт, захиргаанд ажилладаг албан тушаалтанд ашиг олгодоггүй.
  - 4.1. Оролцогчийг төлөөлж буй этгээд нь Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3 дахь заалтад заасан хязгаарлалтад хамаarahгүй.
3. Тендертэй холбоотой нотлох баримт, мэдээллийг холбогдох этгээдээс гаргуулах эрхийг захиалагчид үүгээр олгож байна.
4. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер нээснээс хойш [30 ба түүнээс дээш хоногийн тоо] хоногийн хугацаанд хүчинтэй байна<sup>1</sup>
5. Тендерийн баримт бичгийн тендер шалгаруулалтын зааварчилгааны 6 дугаар зүйл, 13.4 болон 17.1-д заасныг зөрчсөн, эсхүл тендерт хуурамч баримт бичиг, мэдээллийг хүргүүлсэн бол уг тендерийг илт худал мэдээлэл бүхий тендер гэж тооцохыг хүлээн зөвшөөрч байна.
6. Тендерт санал болгосон бараа нь оюуны өмчийн зөрчилгүй, эрхийн болон биет байдлын догодолгүй болохыг баталж байна.
7. Тендерийг холбогдох журмын дагуу бусад оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч, тендерийг нууцлах аливаа үүргээс захиалагчийг бүрэн чөлөөлж байна.

**Баталгаажуулсан: Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд, эсхүл түүнээс эрх олгогдсон этгээдийн нэр, албан тушаал, гарын үсэг, байгууллагын тамга, тэмдэг]:**

**Хаяг мэдээлэл:**

**Маягт 2: Ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээний мэдээлэл**

Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Хугацаа /эхэлсэн, дууссан/

**Маягт 3:Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл**

Оролцгчийн нэр: [түншлэлийн гишүүн тус бүр бүрэн дуусгавар болсон гэрээ тус бүрээр бөглөнө].

1.	Захиалагчийн нэр
2.	Гэрээний нэр
3.	Гэрээний дугаар
4.	Гэрээ байгуулсан огноо
5.	Гэрээ дуусгавар болсон огноо
6.	Гэрээний дүн
7.	Гэрээ гүйцэтгэсэн хаяг, байршил <input type="checkbox"/> Үндсэн нийлүүлэгч <input type="checkbox"/> Түншлэлийн гишүүн <input type="checkbox"/> Туслан гүйцэтгэгч

**Маягт 4: Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл**

Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Гэрээ эхэлсэн хугацаа	Хүлээгдэж буй гүйцэтгэлийн хувь, мөнгөн дүнгээр	Дуусах хугацаа

**Маягт 5: Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт**

	Нууцалсан баримт бичиг, мэдээлэл	Нууцалсан хууль зүйн үндэслэл
1.		
2.		
3.		
4.		
5.		

## V БҮЛЭГ. ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ

### Санамж

Захиалагч, түүнээс томилсон үнэлгээний хороо нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн дагуу тендер шалгаруулалт зохион байгуулж бараа худалдан авахад энэхүү гэрээний нөхцөлийг боловсруулж ашиглана.

Гэрээний ерөнхий нөхцөл (цаашид “ГЕН” гэх) болон гэрээний тусгай нөхцөл (цаашид “ГТН” гэх), түүнд заасан бусад баримт бичиг нь захиалагч, гүйцэтгэгч талуудын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох баримт бичиг болно.

Энэ гэрээ нь захиалагчаас бараа, түүнтэй холбогдох бараа худалдан авах харилцааг зохицуулсан жишиг заалтуудыг агуулна. Гэрээний нөхцөлийг боловсруулахад ГЕН-д өөрчлөлт оруулахгүй.

ГЕН-ийн холбогдох зүйл, заалтыг тодруулах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах бол ГТН-ийн холбогдох заалтад тухайн бараа худалдан авах нөхцөлд тохируулан өөрчлөлт оруулан ашиглана. Гэрээний нөхцөлийг бэлтгэхэд дараахыг анхаарна:

1. ГЕН-ийн аль нэг зүйлд тодорхой мэдээллийг ГТН-д тусгахаар заасан бол холбогдох мэдээллийг ГТН-д заавал оруулна. ГЕН-ийн аль нэг зүйл, заалтыг тухайн бараа худалдан авахад хэрэглэхгүй бол энэ тухай ГТН-д тусгах;
2. Гэрээ баталгаажуулах маягтад шалгарсан оролцогчийн мэдээлэл болон “хамгийн сайн” үнэлэгдсэн тендерийн мэдээллийг тусгах;
3. Гэрээний үнийг тендерийн үнэд залруулга болон хөнгөлөлтийг тооцож, нэг валютад хөрвүүлсний дараах үнээр тогтоох;
4. Нийлүүлэх бараа, дагалдах үйлчилгээний дэлгэрэнгүй тодорхойлолт, зураг зэргийг гэрээнд хавсаргах;
5. ГЕН, ГТН болон холбогдох хавсралтууд нь өөр хоорондоо зөрчилдөхгүй байх;
6. Гэрээ баталгаажуулах маягтын хаалтан дотор бичсэн жишээ, зааврыг тендер шалгаруулалтын үр дүнд шалгарсан тендерийн нөхцөлд тохиорох үг өгүүлбэр, too хэмжээ зэрэгт нийцүүлэн тусгана. ГТН-д заасан зарим жишээ, нөхцөлийг зөвхөн санаа өгөх зорилгоор оруулсан ба тухайн гэрээний онцлогийг харгалзан захиалагч эцэслэнэ.

## ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

<b>НЭГ ТОДОРХОЙЛОЛТ БА ТАЙЛБАР</b>	
<b>Тодорхойлолт</b>	<p>1.1. Гэрээнд хэрэглэсэн үг, хэллэг, илэрхийлэл нь дор дурдсан утгыг агуулна:</p> <p>1.1.1. “Бараа” гэж Нийлүүлэгчээс Захиалагчид нийлүүлэхээр Тендерт ирүүлсэн хөрөнгийг;</p> <p>1.1.2. “Дагалдах үйлчилгээ” гэж бараа нийлүүлэхтэй холбоотой угсралт, суурилуулалт, сургалт, засвар үйлчилгээ болон Нийлүүлэгчийн үзүүлэх бусад үйлчилгээг;</p> <p>1.1.3. “Захиалагч” гэж Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;</p> <p>1.1.4. “Нийлүүлэгч” гэж гэрээ байгуулах эрх авсан бөгөөд Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;</p> <p>1.1.5. “Талууд” гэж Захиалагч болон Нийлүүлэгчийг хамтад нэрлэснийг;</p> <p>1.1.6. “Хууль” гэж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг;</p> <p>1.1.7. “Бараа нийлүүлэх нөхцөл” гэж Захиалагчийн техникийн тодорхойлолтод нийцүүлж Тендерт тусгасан бараа бэлтгэх, нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг ойлгоно. Тендерт тусгайллан заагаагүй бараа нийлүүлэх нөхцөлийг Техникийн тодорхойлолтод тусгаснаар ойлгоно. Хуулийн 30.2, 34.2-т зааснаар хэлэлцээ хийсэн тохиролцоо нь Гэрээнд тусгагдсан бол Бараа нийлүүлэх нөхцөлийн нэг хэсэг болно.</p> <p>1.1.8. “Бараа нийлүүлэх газар” гэж барааг хүлээлгэн өгөх болон дагалдах үйлчилгээ үзүүлэх газрыг;</p> <p>1.1.9. “Доголдол” гэж нийлүүлсэн бараа, дагалдах үйлчилгээний барааны шинж байдал, чанар тоо хэмжээ нь Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерээс зөрүүтэй байхыг;</p> <p>1.1.10. “Баталгаат хугацаа” гэж нийлүүлсэн барааг зориулалтын дагуу ердийн байдлаар ашиглах явцад бараанд илэрсэн доголдлыг нийлүүлэгч хариуцах хугацааг;</p> <p>1.1.11. “Гомдлын шаардлага гаргах хугацаа” гэж гэрээгээр баталгаат хугацаа тогтоогоогүй бол Захиалагчаас доголдолтой холбогдуулж Нийлүүлэгчид шаардлага гаргах хугацааг;</p> <p>1.1.12. “Захиалагчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах, гэрээнээс татгалзахаас бусад Гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар Нийлүүлэгчтэй харилцах, хяналтыг хэрэгжүүлэх эрхтэй Захиалагчаас томилогдсон этгээдийг;</p> <p>1.1.13. “Нийлүүлэгчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах, гэрээнээс татгалзахаас бусад Гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар Захиалагчтай харилцах эрхтэй Нийлүүлэгчээс томилогдсон этгээдийг;</p> <p>1.1.14. “Гэнэтийн буюу давагдашгүй хүчиний шинжтэй онцгой нөхцөл байдал” гэж талуудын хараа хяналтаас гадуур болсон, урьдчилан таамаглах боломжгүй, гэрээний үүргийг гүйцэтгэх боломжгүй болгох байгалийн гамшиг, Төрийн эрх бүхий байгууллага, албан</p>

	тушаалтны үйлдэл /эс үйлдэхүй/, гоц халдварт, олон улсын хөл хориотой өвчин, цар тахлын улмаас бүх нийтийн хорио тогтоосон нөхцөл байдал бий болохыг ойлгоно.
<b>Гэрээний тайлбар</b>	<p>1.2.Гэрээг тайлбарлах, хэрэглэхэд дараах журмыг баримтална:</p> <p>1.2.1.Ганц тоог илэрхийлсэн үг нь олон тоог, олон тоогоор илэрхийлсэн үг нь ганц тоог хамааруулж болно.</p> <p>1.2.2.Бүлэг болон зүйлийн гарчиг нь гэрээг системчлэх зорилготой бөгөөд гэрээг тайлбарлахад ашиглахгүй.</p> <p>1.2.3.Зүйл, заалт, үг, өгүүлбэрийг энэ гэрээнд заасан нэр томьёог үндэслэн тайлбарлахад бөгөөд гэрээнд тайлбарлаагүй тохиолдолд гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлана. Хэрэв гэрээний агуулгад үндэслэн тайлбарлах боломжгүй тохиолдолд Иргэний хуульд заасан журмыг баримтлан тайлбарлана.</p> <p>1.2.4.Ерөнхий нөхцөл болон тусгай нөхцөл хоорондоо зөрчилдсөн тохиолдолд тусгай нөхцөлийг баримтална.</p> <p>1.2.5.Гэрээний хэрэгжилтийн явцад харилцах хэл нь Монгол хэл байх бөгөөд гэрээг өөр хэл дээр байгуулснаас хувиуд нь хоорондоо зөрчилдсөн тохиолдолд Монгол хэл дээрх хувийг баримтална.</p>
<b>ХОЁР. НИЙЛҮҮЛЭГЧ</b>	
<b>Бараа нийлүүлэх</b>	<p>2.1.Нийлүүлэгч нь гэрээнд заасан бараа нийлүүлэх нөхцөл, нийлүүлэлтийн хуваарь, ГТН-д заасан хугацааг баримтлан Бараа нийлүүлэх, Дагалдах үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй</p> <p>2.2.Нийлүүлэгч гэрээний дагуу Дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай ажилтан, тоног төхөөрөмж зэргийг Тендерт санал болгосноор оролцуулах ба гүйцэтгэлийн явцад эдгээрт өөрчлөлт орох зайлшгүй шаардлагатай нөхцөл үссэн бол Захиалагчаас урьдчилан бичгээр зөвшөөрөл авна</p> <p>2.3.ГЕН-ийн 2.2-т заасны дагуу өөрчлөлт оруулсан тохиолдолд Захиалагчийн шаардсан техникийн чадавх, туршлагын шаардлагыг хангасан байна.</p> <p>2.4.Нийлүүлэгч нь Барааг нийлүүлэхэд зайлшгүй шаардлагатай баримт бичиг, бусад зүйлийг гаргуулахыг хүссэн тохиолдолд Захиалагч ердийн боломжит хугацаанд гаргаж өгнө.</p>
<b>Бараа нийлүүлэх газар</b>	2.5.Бараа нийлүүлэх болон Дагалдах үйлчилгээ үзүүлэх газрыг ГТН-д заана.
<b>Бараа нийлүүлэх хугацаа, түүнийг сунгах</b>	<p>2.6.Бараа нийлүүлэх хугацааг нийлүүлэлтийн хуваарийг үндэслэн ГТН-д заана.</p> <p>2.7.Нийлүүлэгч дараах нөхцөл бий болсон тохиолдолд бараа нийлүүлэлтийн хугацааг сунгах тухай хүсэлт гаргаж болно:</p> <p>2.7.1.Захиалагч ГЕН-ийн 2.4-д заасан үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй;</p> <p>2.7.2.Барааг гэрээнд заасан хугацаанд нийлүүлэх боломжгүйд хүргэсэн Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон.</p> <p>2.8.Захиалагч ГЕН-ийн 2.7-д заасан нөхцөлийн аль нэг нь бүрдсэн гэж үзвэл Нийлүүлэгчийн хүсэлтийг үндэслэн хугацааг сунгаж болно.</p> <p>2.9.ГЕН-ийн 2.7.2-т заасан нөхцөл байдал үссэн болохыг Нийлүүлэгч нотлох үүрэгтэй.</p>

<b>Барааг хүлээлгэн өгөх</b>	2.10.Нийлүүлэгч нь Барааг ГТН-д заасан нөхцөлөөр хүлээлгэн өгч, дагалдах үйлчилгээг бүрэн үзүүлж, баримт (хүлээлцсэн акт) үйлдэнэ.
	2.11.Нийлүүлэгч нь барааг хүлээлгэн өгч, дагалдах үйлчилгээг үзүүлснээр Захиалагчид барааны өмчлөх эрх шилжинэ.
<b>Барааны гарал үүслийн улс</b>	2.12.Гэрээний дагуу нийлүүлэх Бараа нь Тендерт заасан улсын гарал үүсэлтэй байна. 2.13.Нийлүүлэгчийн Тендерийг шалгаруулахад түүнд давуу эрх олгосон бол үнэлгээний явцад үнийг нь хийсвэрээр бууруулж тооцсон аливаа бараа нь заавал Монгол Улсын гарал үүсэлтэй бараа байна.
<b>Баглаа боодол</b>	2.14.Нийлүүлэгч барааг ГЕН-ийн 2.5-д заасан газар хүртэл тээвэрлэх явцад гэмтэх, муудах, дутах зэрэг доголдлоос урьдчилан сэргийлэх сав, баглаа боодлыг ГТН-д заасны дагуу хийнэ. 2.15.Сав, баглаа боодол, түүний хаягдал нь хүрээлэн буй орчинд учруулах сөрөг нөлөөллийг хамгийн бага байхаар сонгоно. Сав, баглаа боодолд хууль тогтоомжоор хориглосон материал ашиглахыг хориглоно. 2.16.Нийлүүлэгч баглаа боодол, түүний дотор, гадна талд тэмдэглэгээ хийх, баримт бичгийг бэлтгэхдээ ГТН-д заасан шаардлага болон Захиалагчийн тухайн үед өгөх зааварчилгааг мөрдөнө.
<b>Худалдааны нөхцөл</b>	2.17.Гэрээнд Худалдааны нөхцөл (Incoterms)-ийг хэрэглэх бол тендерийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ-ны 20.6-д заасан нөхцөлийг ГТН-д тусгана. 2.18.ГТН-д заагаагүй бол Incoterms 2020 Delivery Duty Paid /DDP/ нөхцөлөөр бараа нийлүүлэлтийн хуваарыт дурдсан газарт хүргүүлэхээр хэрэглэнэ.
<b>ГУРАВ. ЗАХИАЛАГЧ</b>	
<b>Барааг хүлээн авах</b>	3.1.Захиалагч нь барааг хүлээн авч, хүлээлцсэн баримт (хүлээлцсэн акт) үйлдэнэ.
<b>Шалгалт, туршилт</b>	3.2.Нийлүүлэх бараа, дагалдах үйлчилгээ, үйлдвэрлэлийн үйл явц Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерт нийцэж буй эсэхийг хянах зорилгоор Захиалагч шалгалт, туршилт явуулах эрхтэй. Шалгалт, туршилт хийх хугацаа, журмын талаар Захиалагч нь Нийлүүлэгчид бичгээр урьдчилан мэдэгдэнэ.
	3.3.Шалгалт, туршилтын явцыг тэмдэглэл үйлдэн талууд баталгаажуулах бөгөөд бараа, дагалдах үйлчилгээ доголдолтой тохиолдолд Захиалагч доголдлыг арилгуулахаар Нийлүүлэгчид мэдэгдэл хүргүүлнэ. 3.4.ГЕН-ийн 3.3-т заасан мэдэгдлийн дагуу Нийлүүлэгч барааны доголдлыг арилгах арга хэмжээ авна. 3.5.Барааг хүлээн авахаас өмнө Захиалагч шалгасан, туршсан байх нь хүлээн авах үед түүнийг дахин шалгах, турших болон шаардлагатай тохиолдолд барааг хүлээн авахаас татгалзах, доголдолтой холбогдуулж шаардлага гаргах Захиалагчийн эрхийг хязгаарлахгүй. 3.6.Шалгалт, туршилт хийхтэй холбоотой аливаа зардлыг Нийлүүлэгч хариуцна.
<b>Гэрээний үнэ</b>	3.7.Гэрээний үнийг Гэрээ баталгаажуулах маягтад заана. 3.8.Гэрээний үнэд хуулийн 40.4-д заасан үндэслэлээр тохируулга хийх эсэх, тохируулга хийх бол аргачлалыг ГТН-

	д заана.
<b>Төлбөр төлөх</b>	3.9.Захиалагч нь төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхийг үндэслэн ГТН-д заасан хугацаанд төлбөрийг Нийлүүлэгчид төлнө.
	<p>3.10.Нийлүүлэгчийн хүсэлтээр Захиалагч Бараа нийлүүлэх хугацааг ГЕН-ийн 2.8-д заасны дагуу сунгасан бол сунгагдсан хугацаагаар Захиалагчийн төлбөр төлөх хугацааг сунгагдсан гэж үзнэ.</p> <p>3.11.Захиалагч нь гэрээний үүргийг зохих ёсоор гүйцэтгэсэн тухай баримтын хуулбар хувь болон бусад холбогдох баримтыг төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхэд хавсаргахыг шаардаж болно.</p> <p>3.12.Захиалагч урьдчилгаа төлбөр төлөхгүй.</p> <p>3.13.ГЕН-ийн 3.8-д заасны дагуу үнэ тохируулж, гэрээний үнэ өөрчлөгдсөн тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт орсноос хойш өөрчлөгдсөн үнийг баримтална.</p> <p>3.14.Төлбөрийн нэхэмжлэх нь Монгол Улсын Үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэгдсэн байна.</p> <p>3.15.Захиалагч нь алданги болон бусад төлбөр шаардах эрхтэй бол Нийлүүлэгчид төлөх төлбөрөөс суутгана.</p>
<b>ДӨРӨВ. ЭРСДЭЛ БА ХАРИУЦЛАГА</b>	
<b>Захиалагчийн хүлээх эрсдэл</b>	<p>4.1.Захиалагч дараах эрсдэлийг хариуцна:</p> <p>4.1.1.Барааг захиалагчид шилжүүлснээс хойш бараа нь ГЕН-ийн 1.1.14-д заасан болон бусад байдлаар гэмтсэн, устсан;</p> <p>4.1.2.Нийлүүлэгч Барааг гэрээнд заасан хугацаанд хүлээлгэн өгөх тодорхой үйлдэл хийсэн боловч Захиалагч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүлээн аваагүй (доголдолтой бараанд хамаарахгүй) байх хугацаанд ГЕН-ийн 1.1.14-д заасан болон бусад байдлаар Бараа гэмтсэн, устсан.</p>
<b>Даатгал</b>	4.2.Нийлүүлэгч нь барааг үйлдвэрлэх, тээвэрлэх, хадгалах, хүлээлгэн өгөх үед гарч болох эрсдэлээс хамгаалж ГТН-д заасны дагуу даатгуулж, даатгалын гэрээ, гэрчилгээний хуулбар хувийг Захиалагчид ирүүлнэ. Даатгалын хураамжийг Нийлүүлэгч хариуцна.
<b>Доголдол</b>	4.3.Захиалагч бараа, дагалдах үйлчилгээг шалгаж, илэрсэн зөрчил, доголдлын талаар Нийлүүлэгчид мэдэгдэнэ.
	4.4.Захиалагч зөрчил, доголдлыг илрүүлэх зорилгоор барааны далд хэсгийг нээх, шалгалт, туршилт хийх эрхтэй.
	4.5.Захиалагч ГТН-д заасан баталгаат хугацаа эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаа дуусахаас өмнө зөрчил, доголдол арилгах тухай мэдэгдлийг нийлүүлэгчид өгнө.
	4.6.Доголдол арилгах мэдэгдэл өгсөн тухай бүр Нийлүүлэгч уг зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд өөрийн зардлаар арилгана.
	4.7.Нийлүүлэгч зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд арилгаагүй бол Захиалагч өөрийн зардлаар арилгана.
	4.8.Захиалагчийн гаргасан зардлыг Нийлүүлэгч Захиалагчид үл маргах журмаар төлнө.
	4.9.Захиалагч нь ГЕН-ийн 4.7-д заасан зардлыг Чанарын баталгаанаас суутгаж болох бөгөөд Чанарын баталгаа хүрэлцээгүй тохиолдолд илүү гарсан зардлыг Нийлүүлэгч нь Захиалагчид үл маргах журмаар төлнө.
<b>Чанарын баталгаа</b>	4.10.Бараа, дагалдах үйлчилгээний баталгаат хугацааг ГТН-

	<p>д заана.</p> <p>4.11.ГТН-д заасан бол чанарын баталгааг хангуулах зорилгоор баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаанд Чанарын баталгааг гаргуулж болно.</p> <p>4.12.Нийлүүлэгч Чанарын баталгааг хуулийн 43.7-д заасны дагуу баталгаажуулж болно.</p> <p>4.13.ГЕН-ийн 4.12-д заасны дагуу баталгаажуулсан тохиолдолд Захиалагч барьцаалсан мөнгийг баталгаанд заасан дүнтэй тэнцэх хэмжээгээр олгоно.</p> <p>4.14.Баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаанд Бараанд аливаа доголдол илрээгүй бол Чанарын баталгааг чөлөөлнө.</p> <p>4.15.ГЕН-ийн 4.7-д зааснаар Захиалагч доголдлыг арилгасан бол доголдол арилгахтай холбоотой гарсан зардал, хохирлыг суутгаж, баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаа дуусмагц үлдсэн мөнгийг Нийлүүлэгчид олгоно.</p> <p>4.16.ГЕН-ийн 4.7-д заасны дагуу доголдлыг арилгасан тохиолдолд баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаа хэвийн үргэлжилнэ.</p>
<b>Алданги</b>	<p>4.17.Нийлүүлэгч нь барааг хуваарийн дагуу буюу гэрээнд заасан хугацаанд нийлүүлээгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгээр ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Захиалагчид төлнө.</p> <p>4.18.Захиалагч нь төлбөр төлөх үүргээ хугацаандаа гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Нийлүүлэгчид төлнө.</p>
<b>Оюуны өмчийн эрх зөрчих</b>	<p>4.19.Барааг өмчлөх, эзэмших, ашиглах явцад гуравдагч этгээдийн оюуны өмчийн эрх зөрчигдсэн нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон бол буруутай тал нь хариуцлагыг хүлээж, холбогдон гарах зардал, хохирлыг арилгана.</p>
<b>Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал</b>	<p>4.20.Барааг гэрээнд заасан хугацаанд нийлүүлэх боломжгүйд хүргэсэн гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон тохиолдолд Нийлүүлэгч нь энэ тухай нэн даруй Захиалагчийн төлөөлөгчид бичгээр мэдэгдэнэ. Бичгээр мэдэгдэх нь хугацаа шаардахаар бол ГЕН-ийн 6.10-д заасан хэлбэрээр урьдчилан мэдэгдэж болно.</p> <p>4.21.Нийлүүлэгч нь Захиалагчаас зааварчилгаа өгөх хүртэл гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга замыг хайна.</p>
	<p>4.22.Захиалагч ердийн боломжит хугацаанд зааварчилгаа өгөх бөгөөд талууд харилцан зөвшилцэж гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга хэмжээг авна.</p> <p>4.23.Гэрээг хэрэгжүүлэх Захиалагчийн зааварчилгаа, Нийлүүлэгчийн авсан арга хэмжээ үр дүнд хүрээгүй тохиолдолд Нийлүүлэгч ГЕН-ийн 2.7-д заасан хүсэлт гаргаж болно.</p>
<b>Үүрэг гүйцэтгүүлэх нэмэлт хугацаа</b>	<p>4.24.Гэрээний нэг тал нь үүргийн зөрчил гаргасан тохиолдолд нөгөө талд үүргийн зөрчлийг арилгах нэмэлт хугацаа тогтоож, мэдэгдэл хүргүүлнэ. Нэмэлт хугацаа нь үүргийг гүйцэтгэх ердийн боломжит хугацаа байна.</p> <p>4.25.Иргэний хуулийн 226 дугаар зүйлд заасан үндэслэл бий болсон тохиолдолд эсхүл Нийлүүлэгч ГЕН-ийн 2.13-т</p>

	заасныг зөрчсөн бол нэмэлт хугацаа тогтоохгүй байж болно.
<b>ТАВ. ГЭРЭЭ ДУУСГАВАР БОЛОХ</b>	
<b>Гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах үндэслэл</b>	<p>5.1.Захиалагч дараах үндэслэлийн аль нэг нь хангагдсан тохиолдолд гэрээнээс татгалзах эсхүл гэрээг цуцлах эрхтэй:</p> <p>5.1.1.Нийлүүлэгч гэрээнд заасан хугацаанд үүргээ гүйцэтгээгүй эсхүл зохих ёсоор гүйцэтгээгүйн улмаас Захиалагч үүрэг гүйцэтгэх нэмэлт хугацаа тогтоосон боловч нэмэлт хугацаанд гүйцэтгээгүй;</p> <p>5.1.2.Бараа нийлүүлэх хугацаанд Нийлүүлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацаа дуусч сунгагдаагүй, түдгэлзүүлсэн, хүчингүй болсон;</p> <p>5.1.3.Нийлүүлэгч ГЕН-ийн 6.5-д заасан үүргээ зөрчсөн нь тогтоогдсон.</p> <p>5.1.4.Нийлүүлэгч өөрийн тендерийн давуу эрх тооцуулсан нөхцөлийн дагуу гэрээний үүргийг биелүүлээгүй.</p> <p>5.2.Нийлүүлэгч тендерт оролцох буюу бараа нийлүүлэх явцдаа авлига, залилан мэхлэх гэмт хэрэг үйлдсэн нь шүүх болон эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон.</p> <p>5.3.Захиалагч нь төлбөр хийх хугацаа хэтэрсэн тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш тогтоосон хугацаанд төлбөрийг төлөөгүй тохиолдолд Нийлүүлэгч гэрээг цуцалж болно.</p> <p>5.4.Нийлүүлэгч ямар ч тохиолдолд гэрээнээс татгалзах эрхийг хэрэгжүүлэхгүй.</p>
<b>Гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах мэдэгдэл</b>	5.5.Гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах мэдэгдэлд гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах болсон үндэслэл, цаашид гэрээг дуусгавар болсонтой холбоотой авах арга хэмжээний тухай тусгасан байна.
<b>ЗУРГАА. БУСАД ЗҮЙЛ</b>	
<b>Төлөөлөгч</b>	<p>6.1.Талууд өөрийн төлөөлөгчийг томилж, томилсон төлөөлөгчийн мэдээллийг гэрээ баталгаажуулах маягтад заана.</p> <p>6.2.Төлөөлөгчийн мэдээлэлд түүний эцэг (эх)-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, холбоо барих утас (ажлын болон хувийн), цахим шуудангийн хаяг тэмдэглэгдсэн байна.</p> <p>6.3.Гэрээ хэрэгжүүлэх явцад төлөөлөгч солигдсон бол Төлөөлөгч солигдсон тухай болон түүний мэдээллийг агуулсан мэдэгдлийг нөгөө талд бичгээр хүргүүлнэ.</p> <p>6.4.Төлөөлөгч нь төлөөлүүлэгчээс бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр эрх, үүргээ аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэхийг хориглоно.</p>
<b>Туслан гүйцэтгэгч</b>	<p>6.5.Туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлж байгаа тохиолдолд Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерт зааснаас илүү хувийг туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэхгүй байх үүрэгтэй.</p> <p>6.6.Туслан гүйцэтгэгчийн аливаа зөрчлийг (хугацаа хэтрүүлэх, ажлын доголдол гэх мэт) Нийлүүлэгч хариуцах бөгөөд Туслан гүйцэтгэгч өөрчлөгдсөн тохиолдолд ГЕН-ийн 2.3-д заасан журмыг баримтална.</p>
<b>Нууцлал</b>	<p>6.7.Талууд гэрээг хэрэгжүүлэх явцад олж авсан хуулиар тогтоосон болон байгууллагаас нууц гэж нууцалж хамгаалалтад авсан аливаа мэдээллийг нөгөө тал зөвшөөрсөн эсхүл эрх бүхий байгууллага шаардсанаас бусад тохиолдолд гуравдагч этгээдэд задруулахгүй, дамжуулахгүй, нийтэд ил болгохгүй.</p>

	6.8. Талуудын хувьд нууц мэдээллийг нөгөө талдаа ил болгож байгаа тохиолдолд нууц гэсэн тэмдэглэл хийж, нууцыг задруулахгүй байх мэдэгдлийг хамт өгнө.
<b>Мэдэгдэл</b>	<p>6.9. Гэрээний үүргийн гүйцэтгэлтэй холбоотой бүх мэдэгдэл (зөвшөөрөл, татгалзал, баталгаа, баталгаажуулалт, нэхэмжлэх, гэрчилгээ, шийдвэр, хүсэлт, захидал үүгээр хязгаарлагдахгүй) нь бичгээр үйлдэгдэнэ.</p> <p>6.10. Гэнэтийн буюу давагдашгүй хүчиний шинжтэй онцгой нөхцөл байдал үүссэн тухай мэдэгдлийг ГЕН-ийн 6.9 -д зааснаас өөр хэлбэрээр мэдэгдэж болох бөгөөд мэдэгдлийг баталгаажуулж бичгээр хүргүүлнэ.</p> <p>6.11. Мэдэгдлийг биечлэн хүргүүлэх эсхүл баталгаат шуудангаар гэрээ баталгаажуулах маягтад заасан Төлөөлөгчийн хаягаар илгээнэ.</p> <p>6.12. Дараах тохиолдолд мэдэгдлийг хүлээн авсанд тооцно:</p> <p>6.12.1. баталгаат шуудангаар илгээсэн тохиолдолд шууданд хийсэн өдрөөр, төлбөр төлсөн баримтыг үндэслэн;</p> <p>6.12.2. биечлэн хүргүүлсэн мэдэгдлийг нөгөө талын төлөөлөх эрх бүхий этгээд хүлээн авсан огноогоор, тэмдэглэлийг үндэслэн.</p> <p>6.13. Аль нэг тал нь ажлын газрын хаяг, утас, шуудангийн хаягаа сольсон тохиолдолд нөгөө талдаа нэн даруй бичгээр мэдэгдэнэ.</p> <p>6.14. ГЕН-ийн 6.13-д заасан үүргээ биелүүлээгүйгээс үүсэх үр дагаврыг мэдэгдээгүй тал хариуцна.</p>
<b>Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах</b>	<p>6.15. Дараах тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулна:</p> <p>6.15.1. ГЕН-ийн 2.8-т заасны дагуу хугацаа сунгагдсан;</p> <p>6.15.2. үнийн тохируулга хийсэн.</p>
	<p>6.16. Гэрээний нэмэлт, өөрчлөлтөд талуудын эрх бүхий төлөөлөгч гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно.</p> <p>6.17. ГЕН-ийн 6.15-д зааснаас бусад тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахгүй.</p>
<b>Маргаан шийдвэрлэх</b>	6.18. Гэрээг биелүүлэхтэй холбогдон гарсан аливаа санал зэрэлдөөн, маргааныг талууд зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.
	6.19. Талууд зөвшилцөн, шийдвэрлэж эс чадвал Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

## ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

<b>ГЕН 2.5.</b>	Бараа нийлүүлэх газар: <b>Хөвсгөл аймгийн Нэгдсэн эмнэлэг</b>
<b>ГЕН 2.6.</b>	Бараа нийлүүлэх хугацаа: <b>2024 оны 03 дугаар сарын 15-аас - 2024 оны 12 дугаар сарын 22</b>
<b>ГЕН 2.10.</b>	Бараа хүлээлгэн өгөх нөхцөл: <b>Incoterms 2020, DDP, Хөвсгөл аймгийн Нэгдсэн эмнэлэг</b>  Бараанд холбогдох баримт бичиг: <b>Дагалдах баримт бичиг</b> Угсралт, суурилуулах: <b>үгүй</b>
<b>ГЕН 2.14.</b>	Баглаа, боодол: <b>Баглаа боодол нь тээвэрлэлтийн үеийн нөхцөл, тээвэрлэлт болон ил хадгалалтын үеийн халуун, хүйтэн, хур тунадас болон бусад бүх нөхцөлийг хангалттай тэсвэрлэхээр байна. Баглаа, боодлын хэмжээ, жинг сонгоходоо барааг хүргэх эцсийн цэгийн алслагдсан байдал, тээвэрлэлтийн цэг бүрд ачих, буулгах хангалттай төхөөрөмж байгаа эсэх зэрэг хүчин зүйлсийг харгалзсан байна.</b>
<b>ГЕН 2.16</b>	Баглаа боодол түүний дотор гадна талд тэмдэглэгээ хийх: <b>Зайлшгүй шаардлагатай тэмдэг тэмдэглэгээг зааж өгсөн байна.</b>
<b>ГЕН 2.17.</b>	Худалдааны нөхцөл: <b>Incoterms 2020, DDP,</b>
<b>ГЕН 3.8.</b>	Үнийн тохироулга хийх аргачлал: <b>/Мөрдөхгүй /</b>
<b>ГЕН 3.9.</b>	Төлбөр төлөх хугацаа: Барааг 100 хувь хүлээлгэн өгсөний дараа захиалагчийн хүлээн авсан тухай актыг үндэслэн төлбөрийг гэрээний нөхцлийн дагуу төлнө.
<b>ГЕН 4.2.</b>	Даатгал: Барааг үйлдвэрлэх, худалдаж авах, тээвэрлэх, нийлүүлэх, хадгалах, болон хүргэх үед гарч болох алдагдал, гэмтэлтэй холбоотой эрсдэлийг нийлүүлэгч хариуцаж DDP инкотермсийн нөхцөлийн дагуу даатгуулна.
<b>ГЕН 4.10.</b>	Баталгаат хугацаа:
<b>ГЕН 4.11</b>	Чанарын баталгаа: Чанарын баталгаа шаардах эсэх: <b>Шаардана</b> Чанарын баталгааны дүн:
<b>ГЕН 4.17.</b>	Нийлүүлэгчийн төлөх алданги: Алданги тооцох эсэх: <b>“Тийм”</b> Алдангийн хувь: <b>хоног тутамд 0.1 хүртэл хувиар тооцно</b>
<b>ГЕН 4.18.</b>	Захиалагчийн төлөх алданги: Алданги тооцох эсэх: <b>“Үгүй”</b> Алдангийн хувь:

**ГЭРЭЭ БАТАЛГААЖУУЛАХ МАЯГТ**  
[Тендер шалгаруулалтын нэрийг бичих] гэрээ.  
Дугаар № [Тендер шалгаруулалтын дугаарыг бичих]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэрийг бичих]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэрийг бичих]** (цаашид “нийлүүлэгч” гэх) нь Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерийг хүлээн зөвшөөрч энэхүү гэрээг дараах нөхцөлөөр байгуулав.

Энэхүү гэрээ нь Захиалагч болон Нийлүүлэгчийн хооронд бараа нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэх (цаашид хамтад нь “Бараа” гэх) болон үнэ төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1. Энэ гэрээний дагуу нийлүүлэх Барааны үнэ нь **[гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэлд заасан үнийн дунг тоогоор болон үсгээр бичих]** төгрөг (цаашид “гэрээний үнэ” гэх) байна. Гэрээний үнэ нь санхүүжилтийн дээд хэмжээ байна.
2. Гэрээний үнийг Нийлүүлэгч **[Нийлүүлэгчийн нэрийг бичих]**-ийн харилцах **[Банкны нэрийг бичих]** банкны **[дансны дугаар бичих]** дугаар дансанд шилжүүлнэ.
3. Дор дурдсан баримт бичиг нь цаашид гэрээний хэсэг болно. (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:
  - 3.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
  - 3.2. Нийлүүлэгч тендер илгээсэн маягт;
  - 3.3. Гэрээний тусгай нөхцөл;
  - 3.4. Гэрээний ерөнхий нөхцөл;
  - 3.5. Техникийн тодорхойлолт;
  - 3.6. Бараа нийлүүлэлтийн хуваарь.
4. Гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлаар талуудыг дараах эрх бүхий этгээдүүд төлөөлнө. Үүнд:
  - 4.1. Захиалагчийн төлөөлөгчийн мэдээлэл  
Эцэг/эх-ийн нэр:  
Нэр:  
Албан тушаал:  
Ажлын утас:  
Гар утас:  
Цахим шуудан:
  - 4.2. Нийлүүлэгчийн төлөөлөгчийн мэдээлэл  
Эцэг/эх-ийн нэр:  
Нэр:  
Албан тушаал:  
Ажлын утас:  
Гар утас:  
Цахим шуудан:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг] \_\_\_\_\_

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг] \_\_\_\_\_

## ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗАРЛАЛ

Огноо: **2024.03.06**

Тендер шалгаруулалтын төрөл: Бараа

Тендер шалгаруулалтын нэр: **Бичиг хэрэг, маягт нийлүүлэх**

Тендер шалгаруулалтын дугаар: **ХӨАНЭ/20241211**

Нийт төсөвт өртөг: **28,805.000**

Тендер шалгаруулалтын арга: Харьцуулалт

- Хөвсгөл аймгийн Нэгдсэн эмнэлэг** нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлага, шалгуур үзүүлэлт хангасан аж ахуй эрхлэгчийг тендер ирүүлэхийг урьж байна.
- Тендер шалгаруулалт нь дараах багцуудаас бүрдэнэ: **багцтай**

### Багц № 1: Бүртгэлийн маягт

Дотоодын үйлдвэрлэлээс худалдан авах бараа байгаа бол тодорхой бичих:

#### Багц № 1: Бүртгэлийн маягт

- Үнийн санал дуудах ажиллагаанд шаардлагатай оролцогчийн тоо: **1-ээс дээш**
- Үнийн санал дуудах ажиллагаанд бүртгүүлэх журам:
- Үнийн санал дуудах ажиллагааг **2024 оны 03 сарын 15-ний өдрийн 09 цаг 15-т** эхлүүлж, **2024 оны 03 сарын 15-ний өдрийн 11 цаг 15 минутын** хугацаанд зохион байгуулна.
- Тендерийг **2024 оны 03 сарын 15-ний өдрийн 11 цаг 15 минутаас** өмнө тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаар илгээх ба тендерийг **2024 оны 03 сарын 15-ний өдрийн 11 цаг 25 минутад** нээнэ.
- Тендерийн хувилбарт саналыг зөвшөөрөх эсэх: **“Зөвшөөрөхгүй”**
- Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй эсэх: **“Эрхгүй”**
- Тендер нь түүнийг нээнээс хойш ажлын 30 ба түүнээс дээш өдрийн хугацаанд хүчинтэй байхаар тендерт заана.
- Оролцогч цахим системийн үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээх эрхтэй байна.

**Хөвсгөл аймгийн Нэгдсэн эмнэлэг хурлын заал, 70382562**  
**Mongolmongo1612@gmail.com**